

**Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн  
Өрхийн Чадавхийг нэмэгдүүлж Нийгмийн Цогц Суурь Үйлчилгээний  
хүртээмж, ашиглалтыг сайжруулах хөтөлбөрийн үнэлгээний тайлан**



**Бал Гопал Байдя, Зөвлөх  
2004 оны 7 дугаар сар**

DIRC  
Хөгжлийн Мэдээллийн Төв



## АГУУЛГА

Хуудас

ТАЛАРХАЛ	i
АГУУЛГА	iii
НЭР ТОМЪЕОНЫ ХУРААНГУЙ	v
1.0 ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ТАНИЛЦУУЛГА	1
1.1 Монгол улсын ерөнхий нөхцөл байдал	1
1.2 Үйл ажиллагааны Мастер Төлөвлөгөө	2
1.3 Нийгмийн Цогц Суурь Үйлчилгээний Хөтөлбөр	3
1.4 Үнэлгээ хийх үндэслэл ба түүний зорилго	4
2.0 ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦ	
3.0 ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦАД ОЛЖ ИЛРҮҮЛСЭН АСУУДЛУУД	4
3.1 Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратеги	5
3.1.1 Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратеги йн гол ухагдахуун	6
3.1.2 Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратеги йн бүтэц, сургалтын модул, сургалтын материал	7
3.1.3 Орон нутгийн хэрэгцээнд олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүд нийцэж байгаа эсэх нь	7
3.1.4 Хүн амын эмзэг бүлгийнхэнд үзүүлж буй олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийн өгөөж	7
3.1.5 Эцэг эх, асран хамгаалагч нарын идэвх санаачилгыг өрнүүлэхэд үзүүлж буй өрхийн чадавхийг сайжруулах стратегийн нөлөө	8
3.1.6 Нийгмийн суурь үйлчилгээний үр өгөөжтэй хэрэгцээ буй болгоход Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийг ашиглах нь	8
3.1.7 Нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжийг дээшлүүлэх	9
3.1.8 Нийгмийн суурь үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэрэгсэл	9
3.1.9 Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн бусдад нөлөөлж чадах зан чанар	11
3.1.10 Хүүхдийн бага насны хөгжил дэх эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн оролцоо	11
3.1.11 Нийгмийн суурь үйлчилгээгээр хангах	11
3.1.12 Хяналт ба үнэлгээ	13
3.2 Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийг эзэмших	14
3.2.1 Монгол улсын засгийн газар	14
3.2.2 Түншлэлийг хөгжүүлэх нь	15
3.2.3 Монгол улс дах НҮБ-ын Хүүхдийн сан	16
3.3 Одоогийн чадавхи ба чадавхи нэмэгдүүлэх талаар гаргасан хүчин чармайлт	16
3.3.1 Одоогийн чадавхи	17
3.3.2 Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж ба ашиглалтыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд чадавхийг дээшлүүлэх талаар гаргасан хүчин чармайлт	18
3.4 Зохион байгуулалтын бүтэц ба түүний тогтвортой байдал	18
3.5 Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж ба ашиглалтыг сайжруулах, Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийн талаарх нэмэлт	

зарим нэг ажиглалт	20
3.5.1 Төлөвлөлтийн үйл явц дах айл өрх, орон нутгийн удирдагч, ажилтнуудын оролцоо	21
3.5.2 Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийн санхүүжилтийг төсөвлөх	21
3.5.3 Хүүхдийн төлөө нэмэлт нөөц бололцоог дайчлах	21
3.5.4 НҮБ-ын Хүүхдийн сангаас Олон нийтийн үүсгэл санаачлагатай төсөлд санхүүгийн болон материаллаг дэмжлэг үзүүлэх	22
4.0 ДҮГНЭЛТ	23
5.0 ЗӨВЛӨМЖ	26
ЛАВЛАМЖ	30
<b>ХАВСРАЛТ</b>	
Хавсралт I Зөвлөхийн томилолтын үүрэг	
Хавсралт II Нийгмийн цогц суурь үйлчилгээний хүртээмж ба ашиглалтыг сайжруулах, Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийн асуудлаар зөвлөх Доктор Бал Гопал Байдягийн ажлын хуваарь	
Хавсралт III Зөвлөлдсөн, ярилцсан хүмүүсийн нэрс	
Хавсралт IV НҮБ-ын Хүүхдийн сангийн судалсан баримт бичиг, тайлангуудын жагсаалт	

## НЭР ТОМЪЁОНЫ ХУРААНГУЙ

АХБ	Азийн хөгжлийн банк
ТТА	Төслийн туслах ажилтан
ОНТМХС	Олон нийтэд түшиглэсэн мэдээлэл, хяналтын систем
НЦСҮ	Нийгмийн цогц суурь үйлчилгээ
ХЭС	Хүүхдэд ээлтэй сургууль
ОНҮСТ	Олон нийтийн үүсгэл санаачлагатай төсөл
ЭЗӨДЯБС	Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги
ӨЧНС	Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратеги
ХХИ	Хүний хөгжлийн индекс
БНХЦХ	Бага насны хүүхдийн цогцоор хөгжүүлэх
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХОТБ	Харилцан ойлголцлолын тунхаг бичиг
ҮАҮТ	Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө
ХТҮГ	Хүүхдийн төлөө Үндэсний газар
ХТҮЗ	Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл
ХХХАХҮХ	Хүүхэд хөгжүүлэх, хамгаалах арга хэмжээний Үндэсний хөтөлбөр
ТАХТ	Төслийн арга хэмжээний төлөвлөгөө
ТҮ	Томилолтын үүрэг
НҮБ-ын ХС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
ДБ	Дэлхийн банк
АХ	Ажлын хэсэг
ДЗОУБ	Дэлхийн зөн Олон улсын байгууллага

## 1.0 ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА БА ТҮҮНИЙ ЗОРИЛГО

### 1.1 Монгол улсын тухай товч мэдээлэл

Монгол улс нь 2002 онд нэг хүнд ноогдох дотоодын нийт бtтээгдхтний орлого нь 440 ам.доллар (Дэлхийн банкны 2004 оны мэдээгээр) бүхий хөгжиж байгаа орон боловч бусад хөгжиж байгаа улсуудын дотор нийгмийн салбарын үзүүлэлтээрээ өндөрт ордог юм. Нийгмийн салбарын зарим үзүүлэлт нь (хүн амын бичиг үсэгт тайлагдсан түвшин, сургуулийн элсэлт, хүүхдийн дархлаажуулалт, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг) бүр хөгжиж буй орнуудынхтай жишиж болохуйц өндөр байдаг билээ. Монгол улс энэ ололт амжилтаараа үнэхээр бахархаж болох юм.

Бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад нийгмийн салбарын үзүүлэлт ийнхүү өндөр байгаа нь 1999 онд цаг үеэ дуусгасан социалист системийн үлдээсэн зүйл билээ. Монгол улс 1990 онд коммунист дэглэмээс олон намын тогтолцоо бүхий улс төрийн ардчилсан системд шилжсэн байна. Улс төрийн системийн өөрчлөлтийн зэрэгцээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн нээлттэй эдийн засгийн системд шилжин оржээ. Шилжилтийн эхний жилүүдэд (1990-ээд оны эхэн үед) Монгол улс эдийн засгийн уналтанд орж хүн амын амьдралын түвшин эрс доройтжээ. Энэ үед нийгмийн нийт бүтээгдэхүүн буурч (1990-1993 онд эдийн засаг 23%-аар буурч), инфляци өсөн (1992 онд 326%-д хүрсэн), ажилгүйдлийн түвшин огцом өсч (1997 онд 7.6%-д хүрсэн) улсын олон үйлдвэр хаагджээ (Хүний хөгжлийн тайлан, Монгол улс, 2003 он, ЭЗӨДЯБС, 2003 он). Үүний улмаас ядуурал улам газар авчээ. 1998 онд хийсэн амжиргааны түвшин тогтоох судалгаагаар ядуурал 1995 онд 36.3%, 1998 онд 35.6% буюу нийт айл өрхийн 1/3-ээс дээш хувь нь ядуу амьдарч байгаа дүн гарчээ. Улс төрийн систем задран унаж, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэнээр хүүхэд болон нийгмийн үйлчилгээний салбарт сөрөг үр дагавар авчирлаа. Монгол улсын нийгмийн салбарын хэд хэдэн үзүүлэлт муудав. Ядуурал өсч, хүний хөгжлийн янз бүрийн үзүүлэлтүүд муудахын хирээр амьжиргааны чанар бүхэлдээ доройтов. Шилжилтийн үеийн эхний жилүүдэд Хүний хөгжлийн индекс (ХХИ) буурч байсан бол 1999 оны үзүүлэлт 1990 оныхоос дээшилжээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1: Хэд хэдэн жилээр гаргасан Монгол улсын хүний хөгжлийн индекс

Он	Дундаж нас	Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдсан байдал (%15+жил)	Анхан, дунд, 3 дахь шатны сургуулийн нийт элсэлтийн хувь (%)	Нэг хүнд ноогдох ННБ US\$)	Хүний хөгжлийн индекс
1990	63.7	96.5	60.4	1640	0.652
1992	62.8	97.7	54.3	1266	0.626
1995	63.8	98.9	57.0	1267	0.635
1998	65.1	96.5	62.0	1356	0.651
1999	63.2	97.8	66.0	1707	0.661
2000	63.2	97.8	69.6	1838	0.669
2001	63.4	97.8	69.6	1968	0.674
2002	63.5	97.8	69.7	2125	0.679

Эх сурвалж: Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл, 2003 он, Монгол улсын засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

Хэдийгээр улс төр, эдийн засгийн шилжилт 1990-ээд оны эцсээр тодорхой хэмжээгээр дууссан ч Монгол хүүхдүүд хоол тэжээлийн гачаалтай, хүүхдийн эндэгдэл өндөр, сургууль завсардалт их, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн тоо (гудамжны хүүхэд, биеэ үнэлэгч хүүхэд, хүүхдийн гэмт хэрэг үйлдэгчид гэх мэт) нэмэгдсээр байна. Ийм нөхцөл байдал нь “Хүүхэд, эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлж, тэднийг хамгаалж, хөгжүүлэх талаар Монгол улс, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын ажиллагааны 2002-2006 оны хөтөлбөр” баримт бичгийг боловсруулахад хүргэсэн билээ.

## **1.2 Үйл ажиллагааны Мастер Төлөвлөгөө**

Монгол улс, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн Үйл ажиллагааны Мастер Төлөвлөгөө нь (YAMT) дараах зүйлд чиглэгдэнэ. Үүнд:

- Эрүүл мэнд, хоол тэжээл, боловсролын буурах хандлагатай байгаа үзүүлэлтүүдийг зогсоох, сайжруулах
- Хүүхдэд оруулах засгийн газрын болон иргэний нийгмийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд тус дэм болох
- Ядуурлын шугамнаас дор түвшинд болон янз бүрийн эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг хамгаалах
- Хүүхэд байгалийн гамшигт өртөх эрсдэлийг бууруулахын тулд дэмжлэг үзүүлэх

Өнгөрсөн хугацаанд хамтран ажилласан туршлага дээрээ үндэслэн Нийгмийн цогц, суурь үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг өнөөгийн тее äæëëääáááíú íáñòáä Ò°è°æ°ã°нд доороос дээшээ төлөвлөх үйл явдлыг дэмжсэн, хүүхдийн өсөлт, хөгжилтийн төлөө өрх гэрд тулгуурласан, олон нийтээр тодорхойлж гаргасан зорилтыг биелүүлэхийн төлөө нэгэн хөтөлбөр болгон тусгасан байна.

Нийгмийн цогц, суурь үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр нь доороос дээш нь төлөвлөх явдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн, орон нутагт түшиглэсэн хөтөлбөр билээ. Гэхдээ энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги нь Үйл ажиллагааны Мастер Төлөвлөгөө болон Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгалаа олоогүй байна. Мөн Нийгмийн цогц, суурь үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр үндэсний хэмжээний бусад хөтөлбөртэй хэрхэн холбогдож, ямар үүрэг гүйцэтгэхийг Мастер Төлөвлөгөөнд тайлбарлаагүй байна. Энэ хөтөлбөр Мастер Төлөвлөгөөнд бусад салбарын хөтөлбөртэй адилханаар тусгагджээ. .

## **1.3 Нийгмийн цогц, суурь үйлчилгээний хүртээмж ба ашиглалтыг сайжруулах хөтөлбөр-НЦСҮХАСХ**

НЦСҮХАСХ-ийн гол зорилго нь хүүхдийн өсөлт, хөгжилтийн төлөө олон нийтэд тулгуурласан үйл ажиллагааг дэмжихэд оршино. Үүнд гол нь тойргийн түвшинд (сум, хороо) явуулах үйл ажиллагаа хамаарна. Үйл

ажиллагааны мастер төлөвлөгөө нь тойргоос гадна мужийн (аймаг, дүүрэг) түвшинд чадавхи бий болгохоор төлөвлөгджээ. Учир нь тойргууд (сум, хороо) мужийн (аймаг, дүүрэг) шууд удирдлагад хамаардаг бөгөөд тойргийн (сум, хороо) төлөвлөгөөг муж нь (аймаг, дүүрэг) баталж, хэрэгжилтийн байдалд нь хяналт тавьж, техник дэмжлэг үзүүлдэг байна. Анх 5 мужийн (аймаг, дүүрэг) сонгон авсан тойргуудад (сум, хороо) хэрэгжжээ. НҮБ-ын Хүүхдийн сан өмнөх Үйл ажиллагааны мастер төлөвлөгөөгөөрөө олон нийтэд тулгуурласан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байжээ. Гэхдээ энэ хөтөлбөр нь өрх гэр, олон нийтийг их хэмжээгээр уриалан дуудаж, зохион байгуулж байгаагүйгээс гадна олон нутгийн түвшинд доороосоо дээшээ төлөвлөх зохион байгуулалтыг дэмжихээсээ илүү бараа, материалын эрэлт хэрэгцээг нь хангахад чиглэж байсан байна.

Доороосоо дээшээ төлөвлөх ажил нь нилээд төвөгтэй зорилт бөгөөд ялангуяа өнгөрсөн үедээ дээрээсээ доошоо чиглэсэн төлөвлөгөөтэй байсан Монгол улсын хувьд илүү төвөгтэй байх нь ойлгомжтой. Мөн өргөн уудам газар нутаг, хүн амын сийрэг байршил, дэд бүтцийн буурай хөгжил нь доороосоо дээшээ төлөвлөх үйл хэрэгт илүү төвөг бий болгоно. Мөн төвлөрөлийг задлах үйл явцыг удирдан тэргүүлэх үүрэгтэй засгийн газрын тодорхой байгууллага байхгүй байна. Харин бусад олон оронд ийм үүрэг бүхий орон нутаг хариуцсан яам байдаг билээ.

Хэдийгээр НЦСҮХАС Хөтөлбөр хамрах хүрээгээрээ орон нутагт (аймаг, дүүрэг) хамаарах боловч НҮБ-ын Хүүхдийн сангийн хөтөлбөрүүдийн хувьд чухал байр суурь эзэлдэг. НЦСҮХАС Хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги болгон Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийг 2002 онд 7-8 пайдаа боловсруулжээ. Үйл ажиллагааны одоогийн Мастер төлөвлөгөөнд зааснаар НЦСҮ/ӨЧН стратегийг 2003 онд санаачилж, Монгол улсын нийт 21 аймгийн 5 аймагт, Улаанбаатар хотын 2 дүүрэгт хэрэгжүүлэхээр төлөвлөгджээ. Одоо НЦСҮ/ӨЧН стратегийг сонгосон аймаг бүрийн 2 суманд, сонгосон 2 дүүргийн 2 хороонд хэрэгжүүлэхээр болжээ. Энэ төсөл нийт 67,040 километр газар нутаг, 59,511 хүн амыг хамарч байна. Энэ нь Монгол улсын газар нутгийн 4.46, хүн амын 2.47 хувийг хамарч байна гэсэн үг билээ. Улаанбаатар хотын Баянгол, Багануур дүүргээс бусад газар нь НЦСҮ/ӨЧН төслийн үнэхээр алслагдсан нутаг болж байгаа бөгөөд эдгээрт хүрэхийн тулд Улаанбаатараас хоёр, түүнээс ч олон хоногоор машинаар явах шаардлагатай. НЦСҮ/ӨЧН төслийн хамгийн алслагдсан газар нь Увс аймаг ба тэнд хүрэхийн тулд машинаар 5 хоног явна. НЦСҮ/ӨЧН төсөл хэрэгжиж байгаа нутгийн хүн амын сийрэгшил нь Монгол орны түгээмэл шинж төрх бөгөөд ард олон сумуудад таран суурьшдаг ажээ. Тархай бутархай суурьшсан хүн амд муу зам харилцаагаар үйлчилгээг хүргэх нь үнэхээр хүндрэлтэй бөгөөд ялангуяа -30 хэмээс доош хөрдөг (-40 хүрдэг) өвлийн хүйтэнд нэн хэцүү зорилт юм.

#### **1.4 Үнэлгээ хийх үндэслэл ба түүний зорилго**

Монгол улсын засгийн газар НЦСҮ/ӨЧН төслийг бусад бүх аймагт нэвтрүүлэхээр төлөвлөж НҮБ-ын Хүүхдийн санг дэмжлэг үзүүлэхийг

хүссэн байна. Энэхүү хүсэлтийг харгалзан үзэж, 2004 оны 9 сард хийгдэх тус улсад хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн дунд үе шатны үнэлгээг угтаж уг төсөлд ерөнхий үнэлгээ хийлгэх зөвлөх ажиллуулахаар НҮБ-ын Хүүхдийн сан төлөвлөсөн ажээ. Зөвөлгөө өгөх үйл ажиллагаанаас дараах тодорхой үр дүн гарна хэмээн үзжээ. Үүнд:

- Боллоцоо муутай, эмзэг бүлгийн хүүхдийн өсөлт, хөгжилтөнд чухал ач холбогдолтой нийгмийн суурь үйлчилгээний хэрэгцээг буй болгон хүртээмжийг сайжруулах, хэрэглээг нь дээшлүүлэхэд өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийн үр дүнд үнэлгээ хийх
- Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх нь бодлого, хөтөлбөрийн боловсруулалтанд тус нэмэр болж байгаад үнэлгээ хийх
- Үндэсний болон орон нутгийн түвшинд чадавхи бий болгох үйл ажиллагаанд үнэлгээ хийх
- НЦСҮ/ӨЧН стратегийн зохион байгуулалтын бүтэц ба ӨЧН стратегийн тогтвортой байдалд үнэлгээ хийх
- НЦСҮ/ӨЧН стратегийг хэрэгжүүлэхэд Монгол дах хөгжлийн байгууллагуудтай түншилж байгаа үйл ажиллагааг үнэлэх

Зөвлөхийн томилолтын үүргийг энэхүү баримт бичигт хавсаргасан ба зөвлөх үйл ажиллагааны тодорхой үр дүнг энд тусгасан болно.

## 2.0 ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦ

Зөвлөхийн томилолтын хугацаа нийт нэг сар үргэлжилсэн бөгөөд үүний 13 хоног нь холбогдох баримт бичгүүдийг судлах, хамтран ажилладаг засгийн газрын байгууллагууд, үндэсний хэмжээний хувьцаа эзэмшигч? нартай зөвлөлдөхөд, 6 хоногийг аймаг, сумын түвшинд ӨЧН стратегийн хэрэгжилтийн байдлыг шалгахад, үлдсэн 12 хоногийг дүн шинжилгээ хийж тайлан бичихэд зарцуулсан. НҮБ-ын Хүүхдийн сантай зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү үнэлгээг хийх илүү үр дүнтэй арга нь олон нийтийн түвшинд төслийн бодит хэрэгжилт ямар байгааг аль болох сайн ажиглах явдал хэмээн үзсэн билээ. Улмаар хөдөө их ажиллахын тулд томилолтын нийт хугацааг 1 долоо хоног орчим хугацаагаар сунгасан юм. Зөвлөгөө өгөх үйл ажиллагаа 2004 оны 6 дугаар сарын 14-нд эхэлж, 7 дугаар сарын 20-нд дууссан. Томилолтын нийт хугацааны 14 хоногийг аймаг/дүүрэг, сум/хороодод ажиллахад зарцуулж, нийгмийн доод давхарга дах хувьцаа эзэмшигчидтэй? ярилцах, ӨЧН үйл ажиллагаатай танилцахад зориулав. Хэдийгээр төсөл хэрэгжиж байгаа газруудад ихэвчлэн томилолтоор ажилласан ч гэсэн төслийн бус Өвөрхангай аймгийн Бүрд сумд очиж ажилласан. Мөн каталок сүмийн дэмжлэг, НҮБ-ын Хүүхдийн сангийн техник туслалцаатайгаар өрхийн чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Шувуун фабрикийн орчимд ажилласан юм. Нийт дараах сум/хороодод ажилласан болно. Үүнд:

- Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 9, 10 дугаар хороо
- Дорноговь аймгийн Эрдэнэ сум
- Хэнтий аймгийн Дадал сум
- Дорнод аймгийн Цагаан овоо сум



- Улаанбаатар хотын Багануур дүүргийн 3,4 дүгээр хороо
- Өвөрхангай аймгийн Бүрд сум
- Каталог сүмийн дэмжлэгтэйгээр өрхийн чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Шувуун фабрикийн орчим

Зөвлөхийн ажлын дэлгэрэнгүй хуваарийг Хавсралт II-т тусгав.

Үнэлгээний ажлын турш 4500 километр аялж, төслийн 5 аймгийн 3-т, Улаанбаатарын төслийн 2 дүүрэгт хоёуланд нь очсон. Төслийн нийт 10 сумын 3-т, Улаанбаатарын төслийн бүх 4 хороонд ажилласан билээ. Томилолтын хугацаанд төсөл хэрэгжүүлэгч засгийн газрын байгууллага, аймаг сумын ажилтнууд, үйлчилгээ эрхэлдэг хүмүүс, эцэг эх, асран хамгаалагч, НҮБ-ын Хүүхдийн сангийн ажилтнууд, хандивлагч байгууллагын ажилтан зэрэг 102 хүнтэй уулзсан. Уулзаж ярилцсан хүмүүсийн нэрсийн Хавсралт III-т, НЦСҮ-ний хөтөлбөртэй холбоотой баримт бичгийн жагсаалтыг Хавсралт IV-д тусгасан болно. Төслийн Монгол өвөрмөц нөхцөл байдлыг ойлгоход тус нэмэр болсон бусад баримт бичгүүдийг Лавламжийн жагсаалтанд оруулав.

Үнэлгээний ажил Монгол улсын Их хурлын сонгуультай давхацсан билээ. Түүнээс гадна ихэнх ажилтнууд амралтаа авдаг зуны улиралд энэ үнэлгээ хийгдсэн юм. Энэ 2 хүчин зүйл холбогдох ажилтнуудыг олж уулзахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн юм. Гэсэн хэдий ч зөвлөх янз бүрийн салбарын олон хүмүүстэй уулзан, зөвөлгөө өгч чадсаныг хавсралт III-д дурьдсан хүмүүсийн тоогоор харж болно.

□□□Ү/Ө□□ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа харьцангуй богино байжээ. Ийм учраас үнэлгээг статистик үзүүлэлтийн үр дүнд хийхээс илүү хөтөлбөрийн үйл явцын байдалд хийсэн юм. Гэхдээ ашиглах боломжтой бэлэн тоо баримт болон өрхийн санаа бодлыг үнэлгээнд ашигласан болно.

### **3.0 ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦАД ОЛЖ ИЛРҮҮЛСЭН АСУУДЛУУД**

#### **3.1 Өрхийн Чадавхийг Нэмэгдүүлэх Стратеги**

Хүүхдийн өсөлт, хөгжилтийн цогц бөгөөд оролцоот төлөвлөлт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд НЦСҮ нь нэгэнт ӨЧН стратеги ашигладаг тул энэхүү үнэлгээ маань үндсэндээ ӨЧН Стратегийн үнэлгээ болсон юм. НЦСҮ –ний зорилгоо биелүүлэх явцад олох амжилт нь ӨЧН Стратегийн ерөнхий зарчим, боловсруулалт, бодит хэрэгжилтийн байдлаас хамаарна. ӨЧН Стратегийн эдгээр аспектиудад хийсэн үнэлгээг доор дурьдав.

##### **3.1.1 Өрхийн Чадавхийг Нэмэгдүүлэх Стратегийн гол ухагдахуун**

ӨЧН стратеги нь өрх гэрийг туршилтын суралцах үйл явцад чадваржуулахад гол анхаарлаа хандуулдаг. Энэ стратегиар хүүхдийн өсөлт, хөгжилтөнд шаардагдах нийгмийн цогц, суурь үйлчилгээ хэрэглэх

үр өгөөжтэй хэрэгцээг өрх гэрүүд бий болгох чадвартай болохыг зорьдог. Энэ нь мөн чанартаа маш бодит концепци юм. Харин үйлчилгээ нь хэрэглэхэд бэлэн байх юм уу өрх гэрүүд үйлчилгээг буй болгох бололцоотой нөхцөлд байх ёстой. Өрх гэрийн боловсрол, аливаад дүн шинжилгээ хийж үнэлгээ өгөх, төлөвлөх чадвар нь орон нутгийнхаа бэрхшээлүүдийг ааван туулах, үйлчлүүлэх боломжоо дээшлүүлэхийн тулд олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийг олж тодорхойлж, арга хэмжээ авахад хүргэсэн байна. Гэхдээ зарим тохиолдолд шаардлагатай үйлчилгээ (нэмэлт витамин, асрагч байхгүй зэрэг)байхгүй байх, эсвэл шаардлагатай үйлчилгээг буй болгоход хэтэрхий их зардал гарч (ундны усны эх үүсвэртэй болохын тулд худаг ухан сувагчлал татах зэрэг)улмаар орон нутгийн хэмжээнд шийдвэрлэж чадахгүй байгаа тохиолдлууд байна. Ийм тохиолдолд санхүүгийн болон бусад бэрхшээлийн улмаас үндэсний хэмжээнд ч дэмжлэг үзүүлж чадахгүй байжээ. Ийм байдал нь өрх гэрийг чадваржуулаад ч нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх бололцоогүй болгож байгаа билээ. Ердөө л шаардлагатай байгаа үйлчилгээг авч чадахгүй байгаа гэсэн үг. Энэ нь айл өрхүүдийг урам хугарахад хүргэх, үйлчилгээг сайжруулахын тулд төлөвлөх үйл ажиллагаанд оролцох эрмэлзэлгүй болгох магадлалтай.

### **3.1.2 Өрхийн Чадавхийг Нэмэгдүүлэх Стратегийн бүтэц, сургалтын модул, сургалтын материал**

ӨЧД Стратегийг хэрэгжүүлэх үе шатыг боловсруулах, сургалтын загвар, материал боловсруулах чиглэлээр ихээхэн хүчин чармайлт тавьжээ. ӨЧД Стратегийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй зааварчлагаа боловсруулсан нь ӨЧД Стратегийг орон нутаг хэрэгжүүлэгч нарт чухал гарын авлага болсон байна. Өрх гэрийг чадваржуулах сургалтын материалыг ч насанд хүрэгчдийн суралцах хамгийн зөв зарчим дээр ("Гэрээ цэнхэр өнгөтэй болгоё" хэмээх харах мэдрэмж ашигласан хэрэгсэл)тулгуурлан сайн боловсруулжээ. Энэ үйл явц төсөл хэрэгжүүлэгч болон төсөлд хамрагсадын аль алины зүгээс ихээхэн цаг хугацаа, бэлтгэл шаардсан ажил юм. Олонхи тохиолдолд ийм үйл явц үйлчлэгч ба үйлчлүүлэгч өрхийн цаг хугацааг их авч байгаа тул тохиромжтой бус юм. Үнэндээ ӨЧД төлөвлөлтийн маш сайн, тохиромжтой үйлдэл боловч цаг нилээн шаарддаг болохыг орон нутгийн үйлчилгээний салбарын зарим ажилтнууд хэлж байлаа.Гадны техник туслалцаа, нөөц бололцоо зогсох үед энэ үйл явц тогтвортой үргэлжилж чадах арга зүйн ямар боломж байгаа нь эргэлзээтэй байна. Зөвлөхөөр ажилласан хүнд томилолтоор ажиллаж байх хугацаандаа нэгэн гэр бүлд 2 дах удаагийн үнэлгээ хийсэн туршилтыг ажиглах бололцоо олдсон байна. Урьдчилан бэлтгэсэн үйл явцтай харьцуулахад эсрэгээрээ энэ үнэлгээ хайш яйш, хайхрамжгүй байжээ. Өрх гэрүүдийн оролцоо ч мөн муу байж. Үүнийг Их хурлын сонгуульд олон ажилтнууд дайчлагдсанаар тайлбарлаж болох боловч зөвөлгөө өгөх үйл явц богино байх бололцоотой байжээ.

ӨЧД Стратегийг хэрэгжүүлэх сургалтын материалыг ашиглагч нар өндөр үнэлж байна. Харин ӨЧД Стратегээр тодорхойлогдсон олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зарим

материалууд алга байна. Тухайлбал гэр-цэцэрлэгийн явуулын багш нарын гарын авлага, эцэг эх, сайн дурынханы гарын авлага одоо болтол гараагүй байгааг цохон тэмдэглэв. Орон нутгийн боловсролын байгууллагын арга зүйч нар шаардлага хангахгүй хэмээн үзсэн ноорог материалыг багш нар ашиглаж байна. Хэдийгээр эдгээр нь ӨЧД-ийн сургалтын материал биш ч гэсэн ийм гарын авлага дутагдалтай байх нь ӨЧД Стратегууд тодорхойлогдсон олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулжээ.

### **3.1.3 Орон нутгийн хэрэгцээнд олон нийтийн санаачилсан төслүүд нийцэж байгаа эсэх нь**

ӨЧН Стратегийн олон нийтэд тулгуурласан оролцоог дэмжсэн төлөвлөлтийн үйл явцын эцсийн үр дүн нь туршилтын сум бүрт олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг сум, аймгийн Иргэдийн хурлын дэмжлэгтэйгээр буй болгоход оршино. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төсөлд тухайлбал:

- Явуулын гэр-цэцэрлэг
- Хүүхдийн өсөлтийг хянах өрхөд түшиглэсэн үйл ажиллагаа
- Сургууль завсардсан хүүхдүүдэд зориулсан албан бус хөтөлбөр
- Ариун цэврийн шаардлага хангасан жорлон
- Ундны усыг шалгах
- Гэрийн нөхцөлд ногоо тарих

Нэгэнт эдгээр төслийг олон нийтийн оролцоотойгоор нарийн чанд, системтэй дүн шинжилгээ хийсний үндсэн дээр боловсруулан гаргасан тул сумын эн тэргүүний бэрхшээлийг даван туулахад үнэхээр тус дэм болох юм. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг багийн юм уу багц сонирхлыг хангахаасаа илүүтэй сумын хэмжээний гол бэрхшээлүүдийг арилгахад чиглүүлэхээр сонгон авсан юм. Олон нийтийн үүсгэлтэй төсөл багийн тодорхой хэрэгцээг хангаж чадахгүй зарим баг хэмээн үзжээ. Сумын санхүүгийн болон хүний хүчний нөөц бололцоо хязгаарлагдмалаас орон нутгийн нийтлэг хэрэгцээ нь сумын хэмжээний төлөвлөлтөнд бүрэн хамрагдаж чадахгүй гэж үзэж байгаа юм.

### **3.1.4 Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийн өгөөжийг ядуу, бололцоо муутай, эмзэг бүлгийн хүмүүс хүртэх нь**

НЦСҮД/ӨЧН төслийн туршилтын объектыг сонгохдоо мал малладаг иргэд амьдардаг хөдөө газар, эсвэл зуднаар малаа алдаад, эсвэл ердөө л амьдралын илүү боломж хайж хөдөөнөөс хот орж ирсэн оршин суугчдад анхаарлаа хандуулсан байна. НЦСҮД/ӨЧН төслийн үйл ажиллагаа хамгийн бололцоо муутай, эмзэг бүлгийн хүмүүст хүрч үйлчилдэг тул малчны болон хотод нүүж ирсэн ядуу айлын хүүхдүүд үүнд хамрагдаж байна. Олон нийтийн үүсгэл санаачлагатай тодорхой төслүүд өөрөө ядуу хүмүүст хүрч үйлчлэх бололцоог дээшлүүлдэг. Жишээ нь гэр-цэцэрлэг, ундны усан сан, хүүхдийн өсөлтийг гэрийн нөхцөлд хянах зэрэг төсөл бололцоо муутай, эмзэг бүлгийн хүмүүсийг

аль алийг нь хамрах боломжтой юм. Харин эрүүл ахуйн шаардлага хангасан жорлон, гэрийн нөхцөлд ногоо тарих үйл ажиллагаа нь нилээд зардалтай тул үүний үр ашгийг тэр болгон олон хүн хүртэх боломжгүй. Гэхдээ л олон айл үлгэр жишээ жорлонг дуурайн жорлонгоо сайжруулсан байна.

### **3.1.5 Эцэг эх, асран хамгаалагч нарын идэвх санаачилгыг өрнүүлэхэд үзүүлж буй өрхийн чадавхийг сайжруулах стратегийн нөлөө**

ӨЧН Стратегийн хамгийн чухал үр дүн нь эцэг эх, асран хамгаалагч нарыг хүүхдийн өсөлт, хөгжилтийн талаар мэдлэгтэй болгоход чиглэгджээ. Энэ нь ӨЧН Стратегийн туршлагаар танин мэдэх, үнэлгээ хийх үйл ажиллагааны үр дүн болжээ. Бүх эцэг эх, асран хамгаалагч нартай өрхийн боловсролыг хөхүүлэн дэмжсэн үнэлгээний ажлын явцад уулзаж ярилцсан. Тэдний үзэж байгаагаар энэ үнэлгээ нь хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой хамгийн чухал нийгмийн үйлчилгээний ашиг тус, ийм үйлчилгээ байхгүйн хор уршгийг ойлгоход үнэхээр их тус болсон байна. Орон нутагт үйлчилгээ үзүүлдэг хүмүүс одоо өөрсдөө үйлчлэх гээд гүйгээд байхаас илүү хүмүүс тэдэн рүү ирж үйлчлүүлэхийг хүсдэг болжээ.

### **3.1.6 Нийгмийн Цогц Суурь Үйлчилгээний үр өгөөжтэй хэрэгцээ буй болгоход Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийг ашиглах нь**

Өрх гэрийн боловсролыг дээшлүүлж, үүнийг нь үнэлдэг болсоны ачаар эцэг эх, асран хүмүүжүүлэгч нарын мэдлэг дээшилсэн тул нийгмийн суурь үйлчилгээнд өндөр шаардлага тавих болсон талаар нийгмийн үйлчилгээний салбарынхан ярьж байна. Нийгмийн үйлчилгээний хүмүүс ӨЧН стратегийн ач тусаар өндөр шаардлага тавих болсон бүх сум, хорооны хүмүүстэй санал нэгтэй уулзсан юм. Ингэснээр ч тэдний цаашдын ажлыг хөнгөвчилсөн билээ. Тэд үйлчилбэл зохих хүмүүсээ хайж олох гэж цагаа үрэхээ больжээ. “Бид одоо эцэг эх, асран хамгаалагч нарыг хайж олох гэж цагаа үрэхээ больсон ба эцэг эх, асран хамгаалагч нар харин биднийг эрж хайдаг болсон” гэж Баянгол дүүргийн өрхийн эмч хэлж байна. Айл өрхөөр сайн дурынхан байнга ордог болсон нэгэн шалтгаан нь хүүхдийн өсөлтөнд хяналт тавих, хүүхдийг дархаажуулах, эмэгтэйчүүдийн төрөхийн өмнөх ба төрсөний дараах үйлчилгээ, хүүхдийн сургуулийн өмнөх насны боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгдсэнтэй холбоотой болохыг тогтоожээ. Илүү өргөн хэмжээгээр үйлчлүүлж байна гэдэг хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаагийн бас нэгэн илрэл юм. (3.1.8-ийг үзнэ үү)

### **3.1.7 Нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжийг дээшлүүлэх**

Хүүхдийн сургуулийн өмнөх насны боловсрол, хүүхдийн өсөлтөнд байнгын хяналт тавих, жирэмсэн эхчүүдэд тавих халамж зэрэг нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломж НЦСҮД/ӨЧН Стратегийн бүтээлч үйл

ажиллагааны үр дүнд ихээхэн дээшилсэн байна. Гэр цэцэрлэг байгуулж явуулын багш ажиллуулсан, эцэг эх, багш нарт туслахаар сайн дурынханыг дайчилсан нь хөдөөгийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох боломж олгосон байна. Түүнчлэн сайн дурынханыг дайчилсанаар хүүхдийн өсөлтийг байнга хянахад тус дэм болжээ. Хүмүүс эрүүл ахуйн шаардлага хангасан жорлонгийн ач тусыг улам ойлгон загвар жорлонгоос үлгэр жишээ авч олон айл өрх өөрийн ийм жорлонтой болжээ. Усан сан байгуулж, өрхийн боловсролыг дээшлүүлсэн нь айл өрхийн найдвартай ундны усны хангамжийг сайжруулжээ. Хэдийгээр дээрх үйлчилгээгээр хангагдах бололцоо урьд өмнөх үеэс дээшилсэн ч нийгмийн бүх төрлийн үйлчилгээ жигдрээгүй хэвээр байна.

Сайн дурынханыг дайчлан ажиллуулсан нь нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжийг дээшлүүлсэн ч сайн дурынхантай холбоотой шийдвэрлэвэл зохих хэд хэдэн асуудал байна. Үүнд сайн дурынханд санхүүгийн урамшуулал олгох асуудал юуны өмнө тавигдаж байна. Зарим сумд санхүүгийн урамшуулал олгосон байхад зарим нь олгоогүй байна. Урамшуулал олгосон газар урамшуулал нь хүрэлцээ муутай асуудал ч гарч байна. Эмэгтэй сайн дурын ажилтан гэрлэх юм уу жирэмслэх тохиолдолд түүний сайн дурын үйл ажиллагаа нь тасалдсан тухай дурьдагджээ. Зарим сайн дурынхан чин сэтгэлээсээ ажилладаг байхад зарим нь үгүй байх жишээтэй. Энэ нь тэдний ажил үйлчилгээний чанарт нөлөөлжээ. Зарим салбарын мэргэжилтнүүд, тухайлбал эрүүл мэндийн ажилтнууд сайн дурынхны өрх гэрт өгч байгаа зөвөлгөө, үйлчилгээний чанарт эргэлзэж байна. Эрүүл мэндийн яамны ажилтнууд айл өрхөд буруу зөвөлгөө өгсөн сайн дурынханы тухай бүр мэдээлсэн ажээ.

### **3.1.8 Нийгмийн суурь үйлчилгээг түлхүү хэрэглэж байгаа нь**

Төсөл хэрэгжиж байгаа бүх суманд нийгмийн суурь үйлчилгээг хүртэж байгаа байдлын талаар статистик мэдээлэл авах бололцоогүй байна. Гэвч томилолтын хугацаанд үйлчилгээ үзүүлэгчээс олж авсан мэдээлэл, НҮБ-ын Хүүхдийн санд Увс аймгийн Эрдэнэ сумаас ирсэн үнэлгээний мэдээлэлээс харахад нийгмийн суурь үйлчилгээг хэрэглэх явдал нэмэгдсэн ажээ. Томилолтын хугацаанд очсон бүх сумын эмнэлэг 2001 онтой харьцуулахад 2003 онд амбулаторийн өвчтөнд үйлчилсэн үйлчилгээ нэмэгдсэн хэмээн мэдээлжээ. (Хүснэгт 2) Амбулаторийн өвчтөний тоо янз бүрийн шалтгаанаар өсч болно. Хүн ам өссөнөөс, өвчний тархалт нэмэгдсэнээс, эмнэлгийн өрхөд үйлчлэх арга барил өөрчлөгдсөнөөс юм уу эдгээрийн нийлмэл шалтгаанаас амбулаторийн өвчтөний тоо нэмэгдсэн байж болно.

Хүн амын өсөлтийн улмаас бодож байснаас илүү их үйлчилгээ үзүүлсэн ба ямар нэг өвчний тархалт байгаагүй нь үйлчилгээний энэ өсөлт гол нь ӨЧН стратегийг нэвтрүүлсэнээс айл өрхүүд илүү их үйлчлүүлэх болсонтой холбоотой гэж дүгнэж болно. Үнэхээр ч томилолтын хугацаанд уулзсан хэд хэдэн эмч айл өрх илүү ухамсартай болсон

учраас амбулатороор үйлчлүүлэгчийн тоо нэмэгдсэн болохыг дурьдсан билээ. Хүмүүс ч өвчтөний байдал хүндрэхээс өмнө эмнэлэгт ханддаг болжээ. Энэ нь эмч нарын хэлснээр эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгчийн тоог бууруулжээ. Энэ хандлагыг дараа магадлан баталгаажуулах хэрэгтэй.

Хэрэв эмнэлэгт хэвтээгүй өвчтөний тоо ихсэж, хэвтсэний тоо багасаж байгаа хандлагаыг тодорхой батлаж чадвал эмнэлгийн үйлчилгээний цаашдын стратегид нөлөөлөх болно. Энэ нь Монгол улсын эдийн засагт ихээхэн хэмнэлт үзүүлнэ гэсэн үг билээ. Иймээс үүнд нарийн дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

Хүснэгт 2. Төсөл хэрэгжиж байгаа сум хорооны эмнэлгийн амбулатороор үйлчлүүлэгчдийн тоо

Төрөл	Байрлал	Өвчтөний тоо		Өсөлт %
		2001	2003	
Өрхийн эмнэлэг	Баянгол, Хороо No.9	13,779	22,453	63.0
Өрхийн эмнэлэг	Баянгол Хороо No.10	8,900	29,000	225.8
Сумын эмнэлэг	Дорноговь, Эрдэнэ сум	9,875	11,390	15.3
Сумын эмнэлэг	Хэнтий Дадал сум	3,004 (2002)	5,039	67.7

Эх сурвалж: Эмнэлгийн тайлан

Дорноговь аймгийн Эрдэнэ сум, Увс аймгийн төслийн суманд хийсэн өрхийн 2-догч үнэлгээний дүн анхны үнэлгээний үетэй харьцуулахад үзүүлэлтүүд мэдэгдэхүйц өссөн байгааг харуулав. (Хүснэгт 3) Томилолтын хугацаанд уулзаж ярилцсан нийгмийн салбарын үйлчилгээний байгууллага, хүмүүс НЦСҮД/ӨЧН сумдуудад нийгмийн суурь үйлчилгээний үзүүлэлтүүд их хэмжээгээр сайжирсаныг илтгэсэн юм.

Эрдэнэ сум, Увс аймгийн хоёрдогч үнэлгээнд орсон айл өрхийн тоо нэг дэх үнэлгээнийхээс их байлаа. Нөхцөл байдал сайжирсан нь энэ 2 газрын аль алинд нь ажиглагдсан юм. (Хүснэгт 3)Хэдийгээр бусад НЦСҮД/ӨЧН сумдуудын талаар мэдээлэл байхгүй ч гэсэн энэ 2 газрын амжилт нь ӨЧН стратегийг хэрэгжүүлэх баттай үндэс суурь болон нийгмийн суурь үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.

### 3.1.9 Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн бусдад нөлөөлж чадах зан чанар

Монгол улсын нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг байгууллага дээрээсээ доошоо чиглэсэн төлөвлөх арга барилтай байсан. Энэ нь мөн хуучин Зөвлөлт холбоот улсаас санхүүгийн их хэмжээний дэмжлэгтэйгээр хийгдэж байсан хангамжинд дулдуйдсан үнэтэй систем юм. Энэ системийн үйлчлэгч байгууллага нь эцэг эх, асран хүмүүжүүлэгч нарын

үүрэг, ач холбогдлыг бараг ойшоодоггүй байжээ. Мөн хүүхдийн өсөлт, хөгжилтийг төлөвлөх үйл ажиллагаанд эцэг эх, асран хүмүүжүүлэгч нарын үүрэг огт байхгүй байсныг ажигласан билээ. Зөвөлгөө өгөх явцад уулзсан нийгмийн салбарын үйлчилгээний байгууллагын нийт ажилтнууд ӨЧН Стратегийн төлөвлөх үйл явц дах оролцооны ач тусыг өндрөөр үнэлж байлаа. Тэд эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ амьралын нөхцөл, өсөлт хөгжилтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлтөнд оролцож байгаагийн ач холбогдлыг өндрөөр үнэлж байна.

Нийгмийн салбарын үйлчилгээний байгууллагын ажилтнууд урьд өмнө нь хүүхдийн асуудлыг зөвхөн өөрийн салбарын үүрэг, эрх ашгийн үүднээс авч үздэг байжээ. Харин ӨЧН Стратеги нь хүүхдийн өсөлт, хөгжилтийн асуудал нь цогц болохыг ойлгуулж, бусад салбаруудын үүрэг роль, нийгмийн цогц суурь үйлчилгээний хэрэгцээг гүнээ ухамсарлах болжээ. Тэдний энэхүү ухаарал, нийгмийн үйлчилгээний төрөл бүрийн салбаруудын харилцаа холбоо, хамтын ажиллагаа нь сумдуудад аймаг болон улс орны хэмжээнээс илүү сайн байгааг тэд дурьдсан билээ.

### **3.1.10 Хүүхдийн бага насны хөгжил дэх эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн оролцоо**

НЦСҮ/ӨЧН Стратегийн үр дүнд бага насны хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд эцэг эх, асран хүмүүжүүлэгч нарын оролцоо урьд өмнө байгаагүйгээр нэмэгджээ. Энэ нь айл өрхүүд өрхийн боловсрол, үнэлгээний ач холбогдлыг өндрөөр үнэлдэг болсон, мөн нийгмийн салбарын үйлчилгээний ажилтнуудын зан чанар ӨЧН Стратегийн ач тусаар өөрчлөгдсөнтэй холбоотой. Нийгмийн салбарын үйлчилгээний ажилтнууд ч бага насны хүүхдийн хөгжилд эцэг эх, асран хүмүүжүүлэгч нарын оролцоо их ач холбогдолтой болохыг улам ойлгож авсан байна. Одоо эцэг эх нар ч хүүхдийн өсөлтөнд байнгын хяналт тавих, хүүхэд, эмэгтэйчүүдийг (төрөхөөс өмнө ба төрсөний дараа) нэмэлт витаминаар хангах, гэр-цэцэрлэг зэрэг сургуулийн өмнөх насны боловсролын асуудалд илүү их идэвхитэй оролцдог болжээ. Дадал суманд гэр-цэцэрлэгт ажиллах явуулын багшийн унааг эцэг эхчүүд өөрсдийн хүчээр зохион байгуулсан ажээ.

### **3.1.11 Нийгмийн суурь үйлчилгээгээр хангах**

Төслийн сум, хороодод нийгмийн үйлчилгээний хүртээмжийн талаар тодорхой статистик тоо баримт байхгүй хэдий ч уулзаж ярилцсан Эрдэнэ сум, Увс аймгийн төслийн сумын нийгмийн салбарын үйлчилгээний ажилтнууд, айл өрхүүд төслийн үйл ажиллагаатай тоо баримт гаргаж өгсөн юм. (хүснэгт 3)

Хүснэгт 3. Өрхийн анхдагч ба хоёрдогч үнэлгээний үзүүлэлтийн өөрчлөлт

No.	Бэрхшээл	Эрдэнэ сум		Увс аймаг	
		Анхны үнэлгээ	Удаах үнэлгээ	Анхны үнэлгээ	Удаах үнэлгээ
1.	Хяналтанд ороогүй жирэмсэн эмэгтэй	0/15	0/21	3/25	0/21
2.	Жин нэмэгдээгүй жирэмсэн эмэгтэй	0/15	0/21	3/23	0/21
3.	Төмрийн бэлдмэл хэрэглээгүй жирэмсэн эмэгтэй	0/15	0/21	8/26	2/21
4.	Ажлын хүнд ачаалалтай жирэмсэн эмэгтэй	0/15	0/21	8/25	3/21
5.	Амрах байр, амаржих газар очихгүй жирэмсэн эмэгтэй	0/15	0/21	0/26	0/21
6.	a) Гэртээ хариагүй байгаа төрсөн эмэгтэй	2/13	0/11	0/16	0/10
	b) А витамин, төмрийн бэлдмэл хэрэглээгүй байгаа төрсөн эмэгтэй	2/13	0/14	0/16	0/10
7.	Хүүхэд зайтай төрүүлэх дадлагагүй төрөх насны гэрлэсэн хос	42/381	2/446	40/268	5/533
8.	Оршин суугаа газраа бүртгэлгүй төрөх насны эмэгтэй	15/381	0/446	6/409	2/533
9.	Дан хөхөөрөө биш 0-6 сартай хүүхэд бүхий эх	0/29	0/29	6/20	3/14
10.	Нэмэлт хоолонд ороогүй 6-12 сартай хүүхэд	0/34	0/33	3/24	3/18
11.	өсөлт муутай, өсөлтийг нь банга хэмждэггүй, өсөлтийн муруйгүй 0-59 сартай хүүхэд	17/101	7/247	49/198	45/198
12.	Жин багатай, жингийн нь байнга хэмждэггүй, жингийн график байхгүй 0-59 сартай хүүхэд	17/101	7/247	43/217	38/198
13.	А Витамин хэрэглээгүй 1-5 настай хүүхэд	21/135	3/345	6/222	10/195
14.	a) Вакцин бүрэн хийлгээгүй 0-11 сартай хүүхэд	0/63	0/54	1/263	2/155
	b) Вакцин бүрэн хийлгээгүй 0-5 настай хүүхэд	0/88	2/402	8/222	0/195
15.	Хөгжил дорой 0-2 настай хүүхэд	0/28	4/118	3/120	3/265
16.	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй энэ насны хүүхэд	100/167	23/295	51/225	12/266
17.	Сургууль завсардсан сургуулийн насны хүүхэд	12/215	6/499	37/378	19/349
18.	Тусгай халамж хэрэгтэй амьдралын хэвийн үйл ажиллагаагүй хүүхэд	11/15	5/5	4/11	6/9
19.	Сургуульд хамрагдаагүй 10-19 насны хүүхдүүд	18/19	0/17	45/145	14/149
20.	Бүртгэлгүй 0-18 насны хүүхдүүд	0/0	0/877	1/783	6/794
21.	Дны цэвэр ус хэрэглэдэггүй юм уу хэрэглэх бололцоогүй өрх	450/480	40/544	288310/358	113224/425
22.	Ногооны талбайтай өрх	450480/480	40532/544	310351/358	224262/425
23.	Иоджуулсан давс хэрэглэдэггүй өрх	48050/480	5320/544	351288/358	362113/425
24.	Рүүл ахуйн шаардлага хангасан жорлонтой өрх	343/480	258/544	316/358	275/425
25.	Олон нийтийн дунд хүүхдийг дарамталж, хүчирхийлж байгаа талаар мэддэг өрх	397/480	39/544	274/358	197/425
26.	Хүүхдэд таарамжгүй нийгэм байгааг ойлгодог өрх	428/480	40/544	355/358	218/425
27.	Эцэг эхийн үүргээ зөв биелүүлэхгүй байгааг мэдэрдэг өрх	N/A	6/544	N/A	261/425



Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн сан

Энэ хүснэгтээс харахад ӨЧН Стратегийг нэвтрүүлсэнээр нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж их хэмжээгээр нэмэгджээ. Нэгэнт энэ төсөл амьдралын бололцоо муутай хүмүүс амьдардаг сум, хороонд хэрэгжиж байгаа тул нийгмийн суурь үйлчилгээний хүрээ нэмэгдэх нь тэдгээрийн хүүхдүүдэд үзүүлж байгаа нийгмийн үйлчилгээ нэмэгдсэн гэсэн үг юм. Гэхдээ энэ төсөл хүн амын өчүүхэн хувийг (Монгол улсын нийт хүн амын 2.47%) хамарч байгааг цохон дурьдах шаардлагатай байна. Тийм ч учраас НЦСҮ-ий стратеги хэрэгжиж байгаа газарт бий болсон ахиц дэвшил нь Монгол улсын амьдралын бололцоо муутай нийт хүмүүсийн байдлыг өөрчлөхөд маш өчүүхэн нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 3. Айл өрхөд хийсэн анхдагч ба хоёрдогч үнэлгээний үзүүлэлтийн өөрчлөлт

Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн сангийн баримт бичиг

### **3.1.12 Хяналт ба үнэлгээ**

Монгол улсын нийгмийн үйлчилгээний систем өөртөө хяналт тавьдаг нарийн дэг журам бүхий уламжлалтай. Энэ систем нийгмийн үйлчилгээний хүртээмжийн талаар статистик тоо баримт гарган өгдөг боловч үүнийг зөвхөн нийгмийн үйлчилгээний салбарын хүмүүс л үзэж ашиглах бололцоотой болохоос ердийн эцэг эх, асран хүмүүжүүлэгч нарт олддоггүй байжээ.

Үнэ асуудлыг хөндөн тавихын тулд олон нийтэд тулгуурласан мэдээлэл, хяналтын системийг боловсруулжээ. Үнэлгээ хийж байх үед хүүхдийн хөгжлийн ажлтан, орон нутгийн улт төрийн ажилтнуудад зориулсан олон нийтэд тулгуурласан мэдээлэл, хяналтын системийн гарын авлага дуусах шатандаа байсан юм.

Одоо энэ хөтөлбөрийн үр дүнд статистик үзүүлэлтээр хяналт тавих явдал сум, аймгийн түвшинд төдийгүй хамт, олон, өрх гэрийн хэмжээнд хийгдэх болжээ. Өрх гэр хяналт тавих чадвартай болж, хяналт хийдэг энгийн арга хэрэгсэл (Гэрээ цэнхэр болгох) эзэмшжээ. Мөн өрхийн үнэлгээ нь хамт олон, айл өрхийн түвшинд байдлыг хянах бололцоо олгосон байна. Багийн хэмжээнд мастер? хуудас нэвтрүүлсэнээр хяналт тавих үйл ажиллагаанд тус дэм болжээ.

Гэхдээ саяхан болсон сонгууль зэрэг янз бүрийн шалтгаанаар өрхийн үнэлгээг бүх газарт хийгээгүй нь ажиглагдав. Өрхийн хоёрдогч үнэлгээнд хийсэн ажиглалтаар үнэлгээг тийм сайн системтэйгээр зохион байгуулаагүй байна.

### **3.2 Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийг эзэмших**

ӨЧН Стратеги нь Монгол улсын хувьд шинэ зүйл юм. Энэ нь хүмүүсийн оролцоо, нийгмийн цогц үйлчилгээг дэмжсэнээрээ Монгол улсад маш

зохистой болохыг уулзаж ярилцсан төв, орон нутгийн бүх хүмүүс дурьдаж байлаа. Гэхдээ тэдний энэ үнэлгээгээр энэ стратеги хэрэг дээрээ Монгол улсын хүндрэлтэй системүүдэд хир зэрэг нэвтрэх бол гэдэг асуулт гарч байна. Хүндрэлтэй системд төвийн болон орон нутгийн засаг захиргааны систем, үйлчилгээг хүргэх, төлөвлөхөд ӨЧН Стратегийг загвар болгохыг дэмжсэн Монгол дах НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол улсын хөгжлийн түншүүд хамаарч байна. Энэ гурван системд ӨЧН стратегийг хэрэгжүүлэх талаар доор өгүүлнэ.

### **3.2.1 Монгол улсын засгийн газар**

#### Үндэсний түвшинд

Монгол улс нь “Хүүхэд хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны 2002-2010 оны Үндэсний хөтөлбөр” (ҮАҮХ) баримт бичгийн боловсруулсан Зүүн ази, Номхон далайн анхны улсуудын нэг билээ. ҮАҮХ-ийг Монгол улсын Засгийн газар 2002 оны 12 сарын 4-нд баталсан байна. ҮАҮХ-ийг баталсан засгийн газрын тогтоол нь түүнийг хэрэгжүүлэх нь яамд, аймгийн засаг дарга нарын үүрэг болохыг тодорхой заажээ. Мөн ҮАҮХ нийгмийн цогц, суурь үйлчилгээ, айл өрхөнд тулгуурласан хандлагын талаарх үзэл баримтлалтыг тодорхой тусгасан байна. (2002 онд батлагдсан ҮАҮХ-ийн 8 дугаар хуудсан дах 6.6 зүйл, 15-16 дугаар хуудсан дах 17.1-17.3 дугаар зүйл )

ҮАҮХ-ийг боловсруулж баталсан нь үндэсний хэмжээний хөгжилд хүүхдийн асуудлыг авч үзэж байгаагийн тод илрэл болж байна. Гэхдээ үүнийг ӨЧН Стратегийн амжилт хэмээн үзэх нь хүндрэлтэй. Энэ нь ӨЧН Стратегис илүүтэй НҮБ-ын Хүүхдийн сангийн ерөнхий хүчин чармайлтын үр дүн билээ.

Гэхдээ НЦСҮ/ӨЧН бодлого, стратеги зарим нэг шууд нөлөө үзүүлжээ. Энэ нь тухайлбал Бага насны хүүхдийн хөгжлийн талаарх Үндэсний нэгдсэн бодлого, Хүүхдэд ээлтэй сургуулийн бодлого, Нийгмийн халамжийн стратегийн баримт бичиг, Эрүүл ахуйн үндэсний бодлого, хөтөлбөр зэрэг болно. Эдгээр бодлого, стратегийн баримт бичгүүдэд НЦСҮ/ӨЧН стратегийн бүтээлч хандлагуудыг авч үзсэн байна.

НЦСҮ/ӨЧН Стратеги нь үндэсний эдгээр бодлогуудыг хэрэгжүүлэх үйл явцад ч тус дэм болжээ. Бага насны хүүхдийн хөгжлийн талаарх үндэсний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зааварчлагааг хэдийнээ боловсруулжээ. Мөн Хүүхдийн өсөлт, хөгжилтийг олон нийтэд тулгуурлан хянах талаар зааварчилгааны эх боловсрогджээ. Энэ хоёр ажилд ӨЧН стратегийн батлагдсан арга барил маш их тусгалаа олсон юм.

Үндэсний хэмжээнд, дээд түвшинд ихээхэн дэмжлэг үзүүлж байгаа ч НЦСҮ/ӨЧН стратегийг үндэсний хэмжээнд бодитоор хэрэгжүүлэх ажил бүрэн хийгдэхгүй байна. Үүний нэгэн баримт нь Эрүүл мэндийн яамнаас гаргасан “Дүгнэлтийн баримт бичиг”-т эрүүл мэндийн салбарт олон нийтийн оролцоо маш хязгаарлагдмал байгааг цохон тэмдэглэжээ. Энэ

баримт бичигт мөн үндэсний хэмжээнд салбар хоорондын зохицуулалт сул байгааг дурьдсан байна.

НЦСҮ/ӨЧН стратегиг бодитоор хэрэгжүүлэх ажил дутагдалтай байгааг төслийн бус Өвөрхангай аймгийн бүрд сумын салбарын ажилтнуудтай уулзаж байх үед яригдаж байсан юм. Сумыг хөгжүүлэх салбарын төлөвлөгөөг салбар хариуцсан ажилтнууд ард олонтой уулзахгүйгээр хийдэг байжээ. Товчоор хэлэхэд НЦСҮ/ӨЧН стратеги үндэсний хэмжээний бодлого болон батлагдсан ч хэрэгжүүлэх үйл явц нь бүрэн шаардлага хангаагүй байна. Монгол улсын нийгмийн үйлчилгээний салбарууд дээрээсээ доош чиглэсэн, хангамжинд гол анхаарлаа хандуулсан төлөвлөлттэй хэвээр байгаа нь олон нийтийн оролцоог дэмжих орон зай бодитоор алга байна.

### Орон нутгийн түвшинд

НЦСҮ/ӨЧН стратеги зөвхөн сонгон авсан хөтөлбөрийн өөрийн нь зорилт байжээ. Зарим төслийн аймаг (тухайлбал Хэнтий, Дорноговь) бусдаасаа (Жишээ нь Дорнодоос) илүү амжилттай ажиллаж байна. ӨЧН стратегийн хэрэгжилт хир зэрэг байх нь орон нутгийн улс төрийн ажилтан (засаг дарга) болон орон нутгийн нийгмийн салбарын ажилтнуудын идэрх чармайлтаас ихээхэн хамаарчээ. Орон нутгийн улс төрийн ажилтан амлалтандаа хүрч, санаачлагатай байсан газар ӨЧН стратеги илүү амжилттай хэрэгжиж байна.

Нэгэнт ӨЧН стратеги үндэсний хэмжээнд амьдралд бүрэн хэрэгжээгүй болохоор төслийн аймгууд дах нийгмийн салбар хариуцсан ажилтнуудын дэмжлэг, санаачлага хир их байгаагаас ӨЧН стратегийн хэрэгжилт хамаардаг. Нийгмийн салбарын ажилтнууд өөр ажилд шилжихэд оронд нь ирсэн шинэ хүнд ӨЧН стратегийн мөн чанарыг ойлгуулж чиглүүлэх ажил гардаг ажээ.

### **3.2.2 Хөгжлийн төлөө түншлэл**

ӨЧН Стратеги нь гол хандивлагч байгууллагууд, олон улсын төрийн бус байгууллагуудын сонирхлыг нилээд татжээ. Монголд ажиллаж байгаа, 2004 оноос жилд ойролцоогоор 20 сая ам.долларын төсөвтэй олон улсын төрийн бус томоохон байгууллага болох Дэлхийн зөн НҮБ-ын Хүүхдийн сантай хүүхдийн өсөлт, хөгжилтөнд ӨЧН хандлагыг ашиглахаар хэдийнээ хамтран ажиллах болжээ. (НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөнгийн хооронд хамтын ажиллагааны гэрээ албан ёсоор байгуулагджээ) 2004 оны 7 сарын эхний 7 хоногт НҮБ-ын Хүүхдийн сан Дэлхийн зөнгийн ажилтнуудад ӨЧН талаар сургалт явуулж дэмжлэг үзүүлсэн байна. Каталог сүмийн тусламжтай явагддаг олон нийтийн дэмжлэгтэй үйл ажиллагаа мөн ӨЧН арга барилыг ашигладаг болжээ. Энэ сүмээс явуулж байгаа арга хэмжээнд зориулж НҮБ-ын Хүүхдийн сан ӨЧН талаар сургалт зохион байгуулжээ. Өөр нэгэн олон улсын төрийн бус байгууллага болох Английн Хүүхдийг ивээх сан ажилтнуудаа ӨЧН чиглэлээр сургалтанд хамруулжээ.

Дэлхийн банкны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Тогтвортой амьдрах арга” төсөл төлөвлөлтийн үйл ажиллагаандаа оролцооны аргыг хэрэглэхээр баталжээ. НҮБ-ын Хүүхдийн сангийн тайланд “Дэлхийн банк Улаанбаатар хотын Эрүүл ахуйг сайжруулах төсөлдөө НЦСҮ/ӨЧН стратегийг хэрэгжүүлэх боломжийн судалж байгаа” хэмээсэн байна. НЦСҮ/ӨЧН стратегийг Дэлхийн банк Японы засгийн газраас санхүүжилт хүссэн төслийн боловсруулалтандаа ашиглажээ.

НҮБ-ын Хүүхдийн сангийн тайланд мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй төслүүдэд НЦСҮ/ӨЧН стратегийг хэрэглэх талаар НҮБ-ын Хүүхдийн сан, Азийн хөгжлийн банкны хооронд уулзалт болсон тухай дурьджээ. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага-ЖАЙКА-ын санхүүжилтээр хэрэгжих гэж байгаа Олон нийтэд тулгуурласан усны менежментийн төсөл ч НЦСҮ/ӨЧН стратегийг хэрэглэхээр уулзалт, ярилцлага хийжээ.

### **3.2.3 Монгол улс дах НҮБ-ын Хүүхдийн сан**

Хэдийгээр НЦСҮ/ӨЧН стратеги Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн үлгэр жишээ төсөл ч гэсэн энэ стратегийн бусад төслүүдтэй харилцан зохицон нөлөөлөх байдал сул байна. НЦСҮ-ний хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн аймгийн олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүд салбарын шинж чанартай бөгөөд НҮБ-ын Хүүхдийн сангийн салбарын төслүүд үүнтэй хэрхэн холбогдож дэмжлэг авах нь тодорхойгүй байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн салбарын хөтөлбөрүүд гол нь үндэсний хэмжээний салбарын байгууллагуудыг дэмжих замаар хэрэгждэг нь НЦСҮ стратегиаас нилээд хол хөндий байна. Жишээ нь НҮБ-ын Хүүхдийн сангийн ихэнхи салбарын хөтөлбөрүүдийн Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд НЦСҮ хөтөлбөртэй тодорхой холбоогүй байна.

Монгол улсын нийгмийн үйлчилгээний систем нь тус улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд оршин тогтноход хүндрэлтэй, маш үнэтэй систем юм. Илүү хэмнэлттэй системд шилжих, ялангуяа одоогийн системээр үйлчлүүлж чадахгүй байгаа хөдөөгийн малчид, хотын гэр хороололд нүүж ирсэн ядуу хүмүүст хүрч үйлчлэх шаардлагатай байна. НЦСҮ стратеги нь хүрч үйлчлэх бүтээлч арга замуудыг (явуулын гэр, сайн дурынханыг ашиглах) нэвтрүүлсэн билээ. Салбарын хөтөлбөрүүд ач тусаа өгсөн энэ санаачлагуудыг дэмжин ашиглаж болох юм .

## **3.3 Одоогийн чадавхи ба чадавхи нэмэгдүүлэх талаар гаргасан хүчин чармайлт**

### **3.3.1 Одоогийн чадавхи**

#### Засгийн газрын хэмжээнд

ӨЧН арга барилыг салбарын яамууд дэмжиж байгаа ч гэсэн тэдний ӨЧН стратегийг хэрэгжүүлэхэд орон нутгийн түвшинд техник туслалцаа үзүүлж чадах мэргэжлийн чадавхи бүрдээгүй байна. НЦСҮ стартегийг

хэрэгжүүлэх гол байгууллага болсон Хүүхдийн төлөө Үндэсний газар ч ӨЧН аргыг хэрэгжүүлэхэд хангалттай дэмжлэг үзүүлэхүйц чадавхижуулах хэрэгтэй байна. НЦСҮ стратегийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн ажилтнуудад ӨЧН асуудлаар сургалт зохион байгуулсан байна. Гэвч тэд дадлага хийж, туршлагаа нэмэгдүүлэх бололцоо муугаас мэргэжлийн түвшинд ажиллах болоогүй байна.

#### НҮБ-ын Хүүхдийн сангийн хэмжээнд

Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сан үндэсний болон орон нутгийн хэмжээнд НЦСҮ/ӨЧН стратегийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн техникийн дэмжлэг авахаар олон улсын зөвлөх ажиллуулахаар бодож байжээ. Олон улсын зөвлөх өөрийн гэрээг дуусмагц Монгол улсаас 2004 оны 8 дугаар сард гарахаар төлөвлөсөн байсан. Нэгэнт доороос нь дээш нь төлөвлөх үйл яву, ялангуяа ӨЧН концепци Монгол улсын хувьд шинэлэг зүйл учраас Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сан болон үүний гадна талд НЦСҮ/ӨЧН стратегийг үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх мэргэжлийн хүн дутмаг байна. НЦСҮ хөтөлбөрийг хариуцсан төслийн туслах ажилтан хөтөлбөрийн цаас бичгийн (3.5.4-ийг үзнэ үү)болон бусад ажилд хэт дарагддагаас уг хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих цаг их муутай байдаг байна. Түүнд мөн ӨЧН стратегийг хэрэгжүүлэхэд техник дэмжлэг үзүүлэх туршлага хэрэгтэй байна. НҮБ-ын Хүүхдийн сан саяхан хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд менежментийн дэмжлэг үзүүлж хяналт тавьж байх зорилгоор Увс аймагт (Нэгэн холын аймаг) хээрийн outpost? байгуулжээ. Энд орон нутгийн төслийн туслах ажилтан ажилладаг ба энэ ажилтны ч ӨЧН стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэх үзүүлэх чадавхийг нь дээшлүүлэх шаардлагатай байна.

Мастер төлөвлөгөөний хөтөлбөрүүдийн боловсруулалт Олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний орон нутгийн төлөвлөлтийн агуулгатай их нийтцэй биш байгаа билээ. Улмаар боловсон хүчний хангамж ч Олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний орон нутгийн төлөвлөлтийн агуулгатай нийцэхээсээ илүү салбарын төсөлтэйгээ илүү зохицдог ажээ.

ӨЧН стратегийн хэрэгжилт эхлээд ердөө нэг жил болж байгаа (зарим тохиолдолд үүнээс ч бага хугацаагаар)гэдгийг, тийм ч учраас НҮБ-ын Хүүхдийн сан энэ арга хэмжээнд техник дэмжлэгийг доод тал нь нэгээс хоёр жилийн хугацаагаар үзүүлэх шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэж байна. Иймээс ӨЧН стратегийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн сангийн ч, түүний гадна байгаа байгууллагын ч чадварыг дээшлүүлэх хэрэгтэй. Ингэхдээ зөвхөн Олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний төсөл хариуцсан ажилтнаар хязгаарлахгүй, бусад салбарын төслийн ажилтнуудын ч чадварыг ч дээшлүүлэх хэрэгтэй юм. Олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний төслийн ажилд сайн дэм болохын тулд мөн салбарын төслийн хоорондын зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй байна.


#### **3.3.2 Нийгмийн цогц, суурь үйлчилгээний хүртээмж ба ашиглалтыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд**

**чадавхийг дээшлүүлэх талаар гаргасан хүчин чармайлт**

ӨЧН стратегийг хэрэгжүүлэх чадавхи буй болгох талаар нилээд тооны семинар, сургалтыг зохион байгуулжээ. Сургалтанд хамрагдагсад бүгдээрээ сургалтын чанарыг өндрөөр үнэлсэн боловч тэд дадлага туршлагаа нэмэгдүүлэх бололцоо муутай ажээ. Энэ байдал нэгэнт бэлтгэгдсэн ажилтнууд ӨЧН стратегийн сургалтыг удирдан зохион байгуулж байх явцад ажиглагдсан юм.

**3.4 Зохион байгуулалтын бүтэц ба түүний тогтвортой байдал**  
НЦСҮХАС хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөө (2002-2006) уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах бүтцийг тодорхойлж өгсөн юм. Доор харуулсан диаграммаар НЦСҮХАС хөтөлбөрийн зохион байгуулалт үндэсний болон, аймаг/дүүрэг, сум/хорооноос бүрдэж байна. Хүүхдийн төлөө Үндэсний газар энэ хөтөлбөрийг хариуцсан үндэсний хэмжээний байгууллага бөгөөд хөтөлбөрийн ерөнхий зохицуулалт хийх, техникийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэгтэй.

Үндэсний хэмжээнд НЦСҮХАС хөтөлбөрийн үйл ажиллагааг дэмжих өөр 2 механизм байна. Үүний эхнийх нь өндөр түвшинд байгуулагдсан, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын орлогч даргаар толгойлуулсан Яам хоорондын зөвлөлдөх хэсэг юм. Энэ хэсэг салбарын яамдууд, төслийн аймгийн өндөр түвшний (орлогч сайд, аймгийн засаг дарга) төлөөлөлтэй ажээ. Энэ хэсэг НЦСҮХАС хөтөлбөрийн хэрэгжилтэнд бодлогын чанартай зөвлөмж өгөх, сурталчлагааны дэмжлэг үзүүлэх үүрэгтэй юм. Нөгөө нэг механизм нь Салбар хоорондын ажлын хэсэг бөгөөд салбарын яамдуудын мэргэжлийн ахлах ажилтнуудаас бүрдэнэ. Салбар хоорондын ажлын хэсгийг Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга толгойлно.



Үндэсний хэмжээнд хүлээх үүрэг хариуцлага тодорхой бус байгаа, мөн Салбар хоорондын ажлын хэсгийн үүрэг хариуцлага хэт их байгаагаас Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавихад маш бага оролцож байжээ. Аймаг дүүргийн олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийн ажилтнууд төлөвлөсөн хэмжээнд оролцож чадаагүй ч үндэсний хэмжээний ажилтнуудыг бодоход харьцангуй сайн оролцож байжээ.

Аймаг/дүүрэг, сум/хорооны НЦСҮХАС хөтөлбөрийн ажлын хэсгийг холбогдох засаг дарга байгуулан тэргүүнээр нь аймаг/дүүргийн түвшинд засаг даргын ажлын албаны дарга, сум/хорооны түвшинд засаг дарга өөрөө голдуу томилогдсон байна. Түвшин бүрийн ажлын хэсгүүд салбар бүрийн төлөөллийг оруулжээ. Хэдийгээр НЦСҮХАС хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтэц бүх түвшинд бий болсон боловч аймаг/дүүрэг, сум/хорооны түвшинд ажил илүү сайн байгаагийн учир нь засаг дарга ажлын хэсгийг шууд томилж, ажлын хэсэг ч ажлаа засаг даргадаа тайлагнадагтай холбоотой. Үндэсний хэмжээнд хүлээх хариуцлага тодорхой бус байгаа, төвийн механизм нь их үр ашигтай байгаагүй хэмээн үздэг. Үндэсний хэмжээний энэ сул тал нь Хүүхдийн төлөө үндэсний газрын хоёрмол статустай холбоотой юм. Хүүхдийн төлөө үндэсний газар нэг талаар Ерөнхий сайдын толгойлдог Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн нарийн бичгийн газрын алба ба, нөгөө талаар Нигиймийн хамгаалал, хөдөлмөрийн яамны харьяа байгууллага ажээ. Энэ нь бусад салбарын үйл ажиллагааг уялдан зохицуулахад саад болдог байна.

НЦСҮХАС-д зохицуулах болон менежментийн дэмжлэг үзүүлэхэд ӨЧН стратегийг хэрэгжүүлэх чадавхийг улам нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хүүхдийн төлөө үндэсний газрын сүүлийн үнэлгээгээр (Редди нар, 2003 он) дараах дутагдлуудыг олж тогтоосон юм. Үүнд:

- Хүүхдийн төлөө үндэсний газарт ажилтнууд нь их солигддог, ажлын гүйцэтгэл муу учраас багаар ажиллах уур амьсгал сул
- Хүүхдийн төлөө үндэсний газарт ажилтнуудын эрмэлзэл сул, ажилтнууддаа шударга бус ханддагаас ажилтнуудын сөрөг хандлага, уур амьсгал
- Хүн хүчний дутагдал
- Санхүүгийн нөөц бололцоо муу
- Менежмент сул

Эдгээр нь үндэсний хэмжээнд хүлээх үүрэг хариуцлага тодорхой бус, салбар хоорондын ажлын хэсгийн гишүүдийн үүрэг хариуцлага их байгаагаар гол нь холбоотой. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд үндэсний хэмжээний ажлын хэсгээс дэмжлэг үзүүлсэн тохиолдол маш цөөхөн байна. Харин аймаг/дүүргийн НЦСҮХАС-ын ажлын хэсгийн гишүүдээс үзүүлсэн дэмжлэг тусалцаа харьцангуй олон боловч бас л төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байна.

Хүүхдийн төлөө үндэсний газрын статусын асуудлыг засгийн газраар хэлэлцүүлэхээр өргөн барьжээ. Их хурлын сонгуулийн дүнгээс үүссэн засгийн газрын тодорхойгүй байдал энэ асуудлыг хэлэлцэх хугацааг хойшлуулж байна.

НЦСҮХАС-ын өнөөгийн зохион байгуулалтын бүтцийн хүрээнд янз бүрийн хувьцаа эзэмшигч? нарын оролцоо бүрэлдэн тогтжээ. Одоогийн энэ бүтэц нь аль ч түвшинд хүүхдийн шууд оролцоог хэрхэн дэмжиж байгаа нь тодорхой харагдахгүй байна.

НЦСҮХАС/ӨЧНС-ын өөр нэгэн үнэлүүштэй асуудал бол Хүүхдийн төлөө үндэсний газар, НҮБ-ын Хүүхдийн сан, аймгийн хооронд байгуулсан гурвалсан гэрээ юм. Төсөл хэрэгжиж байгаа сумын засаг дарга хөтөлбөрийн харилцан ойлголцлолын гурвалсан тунхаг бичигт гарын үсэг зуржээ. Харилцан ойлголцлолын гурвалсан тунхаг бичигт оролцогч гурван талын үүрэг харицлагыг тодорхой заасан байна.

Хэдийгээр “Хүүхэд хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны 2002-2010 оны Үндэсний хөтөлбөр” (ҮАҮХ)-ийг батлах замаар НЦСҮХАС/ӨЧНС бодлогын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ч гэсэн НЦСҮХАС/ӨЧНС төслийн бус бусад газарт хэрхэн үргэлжлэх нь тодорхой заагдаагүй байна. Мөн үүнд зориулсан төсөв санхүүгийн асуудал ч тодорхойгүй байна. Иймээс НЦСҮХАС/ӨЧНС цаашид тогтвортой хэрэгжүүлэхэд санхүүгийн бэрхшээл үндсэн бэрхшээл болох талтай. Тийм ч учраас уулзаж ярилцсан бүх түвшний хүмүүс НҮБ-ын Хүүхдийн сан НЦСҮХАС/ӨЧНС-г цаашид дэмжих нь зүйтэй хэмээж байлаа.

Ихэнх хандивлагч байгууллагууд (олон талын болон хоёр талын, олон улсын төрийн бус байгууллагууд) олон нийтийн оролцоонд тулгуурласан арга механизмийг дэмждэг тул НЦСҮХАС/ӨЧНС-г тогтвортой үргэлжлүүлэхэд гаднын ихээхэн хөрөнгийг дайчлах бололцоо байгаа билээ. Дээр дурьдсанчлан зарим хандивлагч хөгжлийн байгууллагууд (Дэлхийн зөн, Каталок хийд зэрэг) Монгол улсын бусад газар нутагт ӨЧН үзэл санааг хэрэгжүүлэхэд хэдийнээ санхүүгийн туслалцаа үзүүлж эхэлжээ.

### **3.5 Нийгмийн цогц, суурь үйлчилгээний хүртээмж ба ашиглалтыг сайжруулах, Өрхийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийн талаарх нэмэлт зарим нэг ажиглалт**

#### **3.5.1 Төлөвлөлтийн үйл явц дах айл өрх, орон нутгийн удирдагч, ажилтнуудын оролцоо**

Төлөвлөлтийн үйл явцад өрх гэрийн оролцоо нэмэгдсэн байх нь ӨЧН стратегийн шалгуур шинж тэмдэг юм. Орон нутгийн удирдлагууд, ялангуяа сумын засаг дарга төлөвлөлтийн үйл явцад маш идэвхитэй оролцож байна. Зарим сумын (Эрдэнэ, Дадал) засаг дарга бүр онцгой анхаарал тавьж энэ талаар орон нутгуудыг тэргүүлж байна. Тэд төлөвлөх үйл явцад биеэр оролцон ихээхэн цаг зарцуулжээ.



НЦСҮХАС/ӨЧНС төлөвлөлтийн үйл ажиллагаанд сумын ажилтнууд ч идэвхитэй оролцжээ. Томилолтоор ажиллах хугацанд уулзсан бүх ажилтнууд НЦСҮХАС/ӨЧН стратегийг санал нэгтэй сайшааж байлаа.

### **3.5.2 Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийн санхүүжилтийг төсөвлөх**

Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийг төлөвлөх явдал улсын хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийн үе шаттай зохицолдоогүй байна. Ийм нөхцөлд үндэсний хэмжээний санхүүжилтийг эдгээр төсөлд төсөвлөх бололцоо муутай. Гэхдээ явуулын багшийн цалин зэрэг зарим нэг зардлыг улсын хэмжээнд шийдвэрлэж аймгийн төсөвт нь суулгажээ.

Аймгууд өөрийн мэдлийн хэмжээний санхүүжилтйн эх үүсвэрээр хомс юм. Гэхдээ аймгууд олон нийтийн үүсгэл санаачлагатай төсөлд ихээхэн дэмжлэг үзүүлж баталдаг. Өөрийнхөө ядмагхан санхүүгийн эх үүсвэрээс олон нийтийн санаачлагатай төслийг санхүүжүүлсэн аймаг ч байна. Аймаг, сумын хэмжээн дэх Иргэдийн хурал ч олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийг санхүүжүүлэх явдлыг ихээхэн дэмждэг ажээ.

### **3.5.3 Хүүхдийн төлөө нэмэлт нөөц бололцоог дайчлах**

ӨЧН стратегийн оролцооны үйл явцын үр дүнд орон нутгийн түвшинд төлөвлөсөн үйл ажиллагааг хариуцах хүн илүү олон болсон байна. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүд ч ихээхэн хэмжээний нэмэлт нөөц бололцоо дайчлах боломжтой болжээ. Ялангуяа олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдэд оролцож байгаа айл өрхийн нөөц бололцоог дайчлан ашиглаж байна. Аймаг сумдууд мөн олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдэд зориулж хөрөнгө гаргаж байгаа нь хүүхдийн төлөө хийсэн нэмэлт арга хэмжээ болж байгаа юм. Ийм байдлаар хүүхдийн өсөлт, хөгжилтийн төлөө НЦСҮХАС/ӨЧНС нэмэлт 80 сая төгрөгийн (70 мянган ам.доллар)нөөц бололцоог дайчлан ашиглажээ. Энэ нь олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийн нийт зардлын 27.3 хувь болж байна.

Хүснэг 4-өөр үзүүлсэн орон нутгийн хувь нэмэрт янз бүрийн түвшний хүмүүсийн зарцуулсан цагийн үнэ цэнийг тусгаагүй байна. Үүнийг бодиттойгоор тусгасан бол орон нутгийн хувь нэмэр нилээд их байх байлаа.

Хүснэгт 4. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийн төсвийн бүтэц (бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах)

Хөтөлбө рийн аймаг	ОНҮС нийт төслийн төсөв	Орон нутгийн хувь нэмэр				НҮБ-ын Эх үүсвэртэй		
		Нийт	Олон нийтийн	Сум, хороо	Аймаг, дүүрэг	Нийт	САГ	.
Дорнод	34,205,280	5,112,600	3,398,800	35,000	1,678,800	29,092,680	4,102,460	24,990,220
Дорноговь	75,621,738	42,719,600	4,254,000	6,337,600	32,128,000	32,902,138	3,650,100	29,252,038
Хэнтий	35,421,800	4,413,000	2,237,700	1,918,300	257,000	31,008,800	3,080,800	27,928,000
Увс	38,011,200	5,732,500	308,000	5,104,500	320,000	32,278,700	5,748,700	26,530,000
Өмнөговь	47,849,221	13,314,800	6,141,800	813,000	6,360,000	34,534,421	5,609,900	28,924,521
Багануур	30,791,735	1,233,471			1,233,471	29,558,264	890,000	28,668,264
Баянгол	31,702,680	7,519,900	1,755,000	1,324,900	4,440,000	24,182,780	1,402,000	22,780,780
Нийт	<b>293,603,654</b> (100%)	<b>80,045,871</b> (27.3%)				<b>213,557,783</b> (72.7%)		

Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн сан

Мэдээлэл бүрэн бус учраас төрөл бүрийн салбараар орон нутгийн оруулсан хувь нэмэрийг тодорхойлох нь төвөгтэй юм. Дадал сум болон Цагаан овоогоос авсан мэдээллээр бол энэ нь гол нь IECD үйл ажиллагааны, багш, сайн дурынханы цалин байлаа.

### 3.5.4 НҮБ-ын Хүүхдийн сангаас олон нийтийн үүсгэл санаачлагатай төсөлд санхүүгийн болон материаллаг дэмжлэг үзүүлэх

Сумын олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг аймгаар батлагдсаны дараа НҮБ-ын Хүүхдийн сангаар батлуулахаар явуулдаг ба ийм төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах ихээхэн санхүү, материалын дэмжлэгийг НҮБ-ын Хүүхдийн байнга сангаас хүсдэг юм. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийг хүлээн аваад НҮБ-ын Хүүхдийн сангийн холбогдох ажилтнууд шалгахын тулд монголоос англи хэл рүү хөрвүүлнэ. Дараа нь НҮБ-ын Хүүхдийн сангийн холбогдох ажилтаны санал, зөвлөмжийг англиас монгол болгон хөрвүүлж засвар, өөрчлөлт, тодотгол хийлгүүлэхээр аймгаар нь дамжуулан сумтай холбоо барина. Хөтөлбөрийн сум болгонд үзүүлж байгаа дэмжлэгийг НЦСҮХАС тусдаа дэд төсөл хэмээн тооцдогыг энд тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь НҮБ-ын Хүүхдийн сангийн НЦСҮХАС хөтөлбөрийн багийн ажилтнуудад ихээхэн нэмэлт ачаа болдог байна. НЦСҮХАС хариуцсан НҮБ-ын Хүүхдийн сангийн нэг үндэсний ажилтан олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдэд НҮБ-ын Хүүхдийн сангаас дэмжлэг авах цаг их шаардсан ажлаас гадна өөр бусад олон үүрэг хариуцлага хүлээдэг нь ихээхэн хүндрэл үүсгэдэг ажээ. 2004 оны олон нийтийн үүсгэл санаачлагатай

төслүүд НҮБ-ын Хүүхдийн сангаар батлагдаагүй л байна. Энэ байдал нь төслийн хэрэгжилтийг удаашруулж, саад тотгор болж байна.

Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдэд НҮБ-ын Хүүхдийн сангийн үзүүлж байгаа дэмжлэгтэй холбоотой өөр нэгэн асуудал нь НҮБ-ын Хүүхдийн сан батлагдсан хөрөнгийн 80 хувийг л эхлээд шилжүүлдэг явдал юм. НҮБ-ын Хүүхдийн сангаар төслийн хөрөнгийг батлуулж, дараа нь аймгууд руу шилжүүлэх явдал ихээхэн цаг хугацаа шаарддаг тул бүх аймаг, сумын хүмүүс цаг хугацаа хэмнэх зорилгоор нэгэнт батлагдсан төсвийг 100 хувиар нэг мөсөн шилжүүлэхийг хүсч байна. Зарим аймгийн ажилтнууд төслөө хэрэгжүүлэхийн тулд мөнгө зээлэх, өөрийнхөө мөнгийг ч ашиглах явдал гардаг гэв.

Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн сангаас материал, хангамжийн дэмжлэг авах ажил олон саад бэрхшээлтэй байдгаас хэрэгжилтийг удаашруулдаг ажээ. Олон нийтийн үүсгэл санаачлагатай олон янзын төслүүд багахан хөрөнгө зарах янз бүрийн эд материал шаарддаг ба НҮБ-ын Хүүхдийн сан ийм бага үнэтэй зүйлд ч дэг журмыг мөрдөхийг шаарддаг. Цэцэрлэгт хэрэгтэй хямдхан хүүхдийн тоглоом авахад ч НҮБ-ын Хүүхдийн сангийн хангамжийн ажилтан уг тоглоомын үнэ цэнийг байхгүй болгохоор их цаг хугацаа, хүчин чармайлт гаргадаг ажээ.

НҮБ-ын Хүүхдийн сан анх удаагаа олон нийтэд санхүүгийн болон материалыг дэмжлэгийг шууд үзүүлж байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн шугамаар бараа материал хангах хэвийн дэг журам нь үндэсний хэмжээнд салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, ихээхэн үнэ цэнэтэй хангамжинд илүү тохиромжтой билээ. Харин олон нийтэд, багахан хөрөнгийн хангамж үзүүлэхэд энэ дэг журам маш тохиромжгүй байна.

#### 4.0 ДҮГНЭЛТ

Үнэлгээний явцад олж тогтоосон зүйл дээр үндэслэж дараах дүгнэлт хийв.

1. НЦСҮХАС/ӨЧНС үнэхээр богино хугацаанд (нэг жил орчим) хэрэгжсэн ч ӨЧНС үйл ажиллагааны хэд хэдэн бэрхшээлийг эс тооцвоос нилээд нааштай үр дүнтэй болжээ. ӨЧНС-г үндэсний ба орон нутгийн түвшний шийдвэр гаргагч нар, үйлчилгээний байгууллагын ажилтнууд үнэлсэн байна. Олон нийт, айл өрх ч ӨЧНС-г өндрөөр үнэлсэн нь ӨЧНС-ээр дамжуулан олон нийтийн үүсгэл санаачлагатай төсөлд хөрөнгө байршуулахаар амласанаас харагдаж байна.

НЦСҮХАС/ӨЧНС-ийн гол амжилтууд нь:

- Төлөвлөл төнд дороосоо дээшээ оролцох загвар бий болгосон
- Ролцсон айл өрхийн боловсрол дээшилж хүүхдийнхөө өсөлт, хөгжилтийн төлөө арга хэмжээ авах чадвартай болсон.

- Хүрч үйлчлэх бололцоогүй хүүхдэд үйлчилгээ хүргэхэд санаачлагатай байх хандлагыг (гэр цэцэрлэг, сайн дурынханыг дайчлах, өрхийн өсөлтөнд хяналт тавих гэх мэт) буй болгосон. Энэ нь өрхийг чадваржуулсантай нийлээд эрэлт хэрэгцээгээ нэмэгдүүлж үйлчилгээг улам их хүртэх боломжтой болгожээ. Үйлчилгээний байгууллагын ажилтнуудын цагийг ч хэмнэх болжээ. Илүү их үйлчлүүлж, эцэг эх, асран хүмүүжүүлэгчдийн мэдлэг дээшилсэн нь гэр бүлийн боловсрол, үнэлгээний зорилготой ашиглагддаг үзүүлэлтүүдийг сайжруулахад нөлөөлжээ.
  - Хүүхдийн байдалд орсон өөрчлөлтийг гэр бүлийн, олон нийтийн, сумын түвшинд хянаж үнэлж байх энгийн, амьдралд ойр үзүүлэлт болон аргатай болсон байна.
  - Хүүхдийн өсөлт, хөгжилтийн тусын тулд нийгмийн цогц, суурь үйлчилгээний ач холбогдол, хэрэгцэний талаар үйлчилгээний байгууллагын ажилтнууд болон үйлчлүүлэгчдийн мэдлэг дээшилсэн байна.
  - Хүүхдийн аж амьдралыг дээшлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд эцэг эхийн оролцоо ихээхэн чухал болохыг үйлчилгээний салбарын ажилтнууд ойлгоход тус нэмэр болжээ.
2. Сайн дурынханыг дайчилсан нь ихээхэн бүтээлч арга хэмжээ болов. Харин урамшуулал, чанар зэрэг сайн дурынханыг дайчилдсантай холбоотой хэд хэдэн асуудал гарч иржээ.
  3. ӨЧНС-г эзэмших явдал дутуу байна. ӨЧНС засгийн газрын түвшинд, тодорхой хэмжээгээр бодлогод ашиглагдаж байгаа ч доод түвшиндээ, үнэсний хэмжээнд болоогүй байна. Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийн баримт бичгүүдэд ӨЧНС-г тусгасан ч гэсэн төлөвлөлтөнд оролцох арга төслийн бус газруудад хэрэгжээгүй байна. Хөтөлбөрийн зарим аймгууд, тухайлбал Хэнтий, Дорноговь ӨЧНС-г өөрийнхөө бүх суманд нэвтрүүлэхээр шийдсэн ч хэрэгжиж эхлээгүй, зөвхөн ярианы хэмжээнд байна.

Зарим хоёр талын болон олон талын хөгжлийн түншүүд ӨЧНС-г хэрэглэх сонирхолтой байгаагаа илэрхийлж, зарим нь бүр амьдралд хэрэглэж эхэлжээ. Хамт олны хөгжлийн талаар үйл ажиллагаа явуулдаг олон улсын төрийн бус байгууллагууд (Дэлхийн зөн, Английн хүүхдийг ивээх сан, Католок сүм зэрэг) ӨЧНС-г ихээхэн ёонирхож байгаагаа илэрхийлсэн байна. Тэд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр ажилтнуудаа ӨЧНС-ийн сургалтанд хамруулжээ.

4. Хөгжлийн мөрийн хөтөлбөрт хүүхдийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавихад ӨЧНС-ийн амжилт янз бүрийн түвшинд харилцан адилгүй байна. Хөтөлбөрийн сумдууд аймгуудыг бодоход харьцангуй амжилттай байгаа нь сумын хэмжээнд шийдвэр гаргагч аймгийн хэмжээнд шийдвэр гаргагчаас илүү ӨЧНС-ийн үйл ажиллаганд оролцож байгаатай холбоотой.

Хэдийгээр хүүхдийн ашиг сонирхлыг хангах нь үндсэний хэмжээний хөгжлийн мөрийн хөтөлбөрт илүү тусгалаа олж байгаа ч гэсэн үүний өгөөж нь ӨЧНС-д тусахаасаа илүү НҮБ-ын Хүүхдийн сангийн үйл ажиллагаанд илүү тусч байна.

НЦСҮХАС/ӨЧНС олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдэд орон нутгийн нөөц бололцоог дайчлахад илүү амжилт үзүүлжээ. Орон нутгийн хувь нэмэр 70000 ам.долларт хүрсэн нь олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийн зардлын 27.3 хувийг эзэлж байна. Айл өрхүүд ч өөрийн хувь нэмрээ оруулжээ. Энэ нь доороо дээш нь төлөвлөх үйл явц хүүхдийн төлөө нэмэлт эх үүсвэр дайчлахад түлхэц болсныг харуулж байгаа юм.

Энэ тус нэмэрт орон нутгийн ажилтнуудын үнэтэй цаг хугацаа ороогүй ба үүнийг оруулж тооцвол орон нутгийн тус нэмэр илүү өндөр байх билээ.

5. Монгол улс төсвийнхөө нилээд хувийг (2000 онд 52 хувь, 2001 онд 56 хувь) нийгмийн салбарт зориулдаг. Нийгмийн салбарын зардал ч Нийгмийн нийт бүтээгдэхүүнд ННБ өндөр хувь (2000 онд 22 хувь, 2001 онд 24 хувь) эзэлдэг. Нэгэнт нийгмийн салбарт их төсөв төлөвлөдөг тул нийгмийн салбарт ерөнхийдээ, хүүхдэд зориулж нэмэлт эх үүсвэр айдчилна гэдэг маш хүндрэлтэй билээ. Хүүхдийн төлөө засгийн газрын төсвийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн бодит өсөлт бий болгох замаар л зөвхөн хэрэгжих боломжтой. Дэд бүтцийн өсөн нэмэгдэж байгаа шаардлагын үүднээс засгийн газар нийгмийн салбарт зарцуулж байгаа төсвөө хэвээр нь хадгалахад ч хүнд байгаа билээ.
6. НЦСҮХАС/ӨЧНС-ийн нэгэн дутагдал нь техникийн чадавхи буй болгоогүй явдал юм. Доод түвшинд дэмжлэг үзүүлэх чадварын үндэсний болон аймаг, дүүргийн хэмжээнд цаашид бэхжүүлэх шаардлагатай. НҮБ-ын Хүүхдийн сан ӨЧНС-д техник дэмжлэг үзүүлэх ажилтнуудынхаа чадварыг ч сайжруулах хэрэгтэй байна. Хөтөлбөрүүдийнх нь үлгэр болсон ӨЧНС-ын аргаар хэрэгжих олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний төслүүддээ ч НҮБ-ын Хүүхдийн сан ажилтнуудаа хөгжүүлэхээсээ илүү зөвлөхөд найдаж байна. Энэ нь магадгүй ӨЧНС-ийн хэрэгжих хугацаа бага, энэ хугацаанд чадавхи бий болгохоосоо илүү загвар бий болгох, түүнийгээ хэрэгжүүлэхэд илүү анхаарсантай холбоотой байж болох юм.
7. Хэдийгээр засгийн газар НЦСҮХАС/ӨЧНС-г бусад газарт өргөжүүлэхийг хүсч байгаа ч гэсэн НҮБ-ын Хүүхдийн сан, засгийн газрын аль алинд нь хүн хүч, санхүүгийн нэмэлт бололцоо шаардлагатай. Харин нэгэнт туршлага, яадавхитай болсон учраас төслийн аймгуудын төслийн бус суманд өргөжүүлэн хэрэгжүүлж болох юм. ӨЧНС хандивлагч байгууллагуудын сонирхлыг ихээхэн татаж байгаа тул НЦСҮХАС/ӨЧНС-г өргөжүүлэхэд тэдний нөөц бололцоог дайчилж болно.
8. Хүүхдийн төлөө Үндэсний газар нь хүүхдийн төлөө салбар-хоорондын төслийг хэрэгжүүлэх гол хариуцагч байхад хамгийн тохиромжтой байгууллага билээ. Гэхдээ Хүүхдийн төлөө Үндэсний газрын статус, хүчин чадал муу байна. Олон нийтэд тулгуурласан

нийгмийн үйлчилгээний байгууллагын бүтэц янз бүрийн түвшинд зохистой байгаа ч гэсэн холбогдох бүх салбарууд энд хамрагдаагүй байна.

Аймгийн түвшин дэх ажлын хэсэгт гүйцэтгэгч байхаасаа илүү хэлтсийн дарга нар оржээ. Хэлтсийн дарга нарын ачааллаас болж ажлын хэсгийн ажилд цаг заваа гаргаж чадахгүй байна. Тийм учраас аймгийн хэмжээнд гүйцэтгэгч түвшний хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх механизм хэрэгтэй байна.

9. НЦСҮХАС/ӨЧНС-ийн одоогийн бүтцэд хүүхдийн оролцоог огт авч үзүүгүй байна. Гэхдээ олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг төлөвлөхөд хүүхэд оролцож байгаа билээ.
10. ӨЧНС-г хэрэгжүүлэх стратеги бүрхэг байна.
11. НЦСҮХАС/ӨЧНС-г хэрэгжүүлэхэд ажиллагааны бэрхшээлүүд гарч байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн захиргааны үйл ажиллагааны бодлого нь томоохон төсөлд илүү зохимжтой юм. Хэдийгээр ийм бэрхшээл байгаа ч ӨЧНС хандлагаар төлөвлөлтийг хийх нь нийгмийн суурь үйлчилгээг сайжруулж чаджээ.
12. НЦСҮХАС/ӨЧНС НҮБ-ын Хүүхдийн сангийн үлгэр жишээ төсөл хэмээн тооцогддог ч үүний бусад хөтөлбөрүүдтэй холбогдох байдал нь тодорхойгүй байна. Улмаар ОНТНН-ий төсөл хэрэгждэг газруудад хөтөлбөрүүдийн хоорондын зохицуулалт хангалтгүй байна.

## 5. ЗӨВЛӨМЖ

Үнэлгээний явцад олж тогтоосон зүйлүүд, гарга сан дүгнэлтэн дээрээ үндэслэн дараах зөвлөмж өгч байна.

### НЦСҮХАС/ӨЧНС-г өргөжүүлэх

1. НЦСҮХАС/ӨЧНС-ийн нааштай үр дүнг харгалзан үзэж Монгол улсын засгийн газар НЦСҮХАС/ӨЧНС-г бусад аймаг орон нутагт хэрэгжүүлэхийг НҮБ-ын Хүүхдийн сангаас хүссэн билээ. Гэвч байгаа хүчин чадал, гарч байгаа бэрхшээлүүдийн харгалзан үзэж НҮБ-ын Хүүхдийн сан энэ асуудалд болгоомжтой хандах ёстой. Одоогоор, ядахдаа нэг жилийн хугацаанд НҮБ-ын Хүүхдийн сан НЦСҮХАС/ӨЧНС-ийн одоо хэрэгжиж байгаа газарт дотоод хүчин чадлаа сайжруулахад анхаарах нь зүйтэй. Мөн сумын хэмжээнд олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг дэмжихэд захираагы дүрмээ сайжруулах нь зүйтэй.
2. Техник дэмжлэг үзүүлэх чадавхи, захиргааны журмаа сайжруулж чадсан цагт олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдийг үе шаттайгаар бусад аймгуудад өргөж болох юм. Өнөөгийн тээврийн хэрэгслэлээр аймгууд руу хүрэх нь цаг хугацаа ихээхэн шаарддаг тул төслийн Улаанбаатартай ойрхон аймгуудад өргөжүүлэх нь зохистой. Эдгээр аймгуудын хасагдсан сумдуудад үргэлжлүүлж болно. НҮБ-ын Хүүхдийн сан НЦСҮХАС/ӨЧНС-г өргөжүүлэхэд хөгжлийн түнш байгууллагатай харилцаа холбоогоо батжуулж болно.

## Чадавхи буй болгох

3. Хүүхдийн төлөө Үндэсний газар НЦСҮХАС/ӨЧНС-ыг хариуцах зохистой байгууллагын нэг билээ. Гэхдээ түүний хүч чадлыг улам сайжруулах хэрэгтэй байна. НҮБ-ын Хүүхдийн сан Хүүхдийн төлөө Үндэсний газрын боловсон хүчнийг чадваржуулахад дэмжлэг үзүүлэх ёстой. Энэ нь зөвхөн НЦСҮХАС/ӨЧНС-г хэрэгжүүлэхэд ч бус, ерөөсөө Хүүхдийн төлөө Үндэсний газар засгийн газрын хүүхдийн төлөө гол байгууллага болохын нь хувьд, мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн гол түншийн хувьд ингэх шаардлагатай юм. Засгийн газар ч энэ байгууллагыг хэрэгжүүлэгч юм уу зохицуулагч агентлаг байлгахыг даруйхан тодорхой болгох ёстой.

НҮБ-ын Хүүхдийн сан Хүүхдийн төлөө Үндэсний газрыг олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний салбар хоорондын ажлын хэсгийн үүргээ идэвхижүүлэхэд нь туслах хэрэгтэй байна. Салбар хоорондын ажлын энэ хэсэг ивэвхижих нь Хүүхдийн төлөө Үндэсний газрын байр суурийг бэхжүүлнэ. Энэ ажлын хэсэг нь мөн үндэсний хэмжээнд НЦСҮХАС/ӨЧНС-г нэвтрүүлэхэд ихээхэн чухал механизм болох билээ. Мөн энэ ажлын хэсэг олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүдэд салбарын төвсийн дэмжлэг үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм. Аймаг, дүүргийн ажлын хэсгүүдийг бэхжүүлэхэд тус болно.

4. Сумдад хэрэгжүүлэх НЦСҮХАС/ӨЧНС-нд дэмжлэг болохын тулд аймгийн ажилтнуудын чадваржуулахад НҮБ-ын Хүүхдийн сан засгийн газартай нягт хамтран ажиллах ёстой.
5. НҮБ-ын Хүүхдийн сан өөрийнхөө ажилтнуудын чадварыг дээшлүүлэх хэрэгтэй. Өөрийн дотоодын чадавхийг сайжруулахад энэ зөвлөхийн гэрээг сунган өөртөө ч, засгийн газарт ч туслуулахаар ашиглаж болно. Орон нутгийн төрийн бус байгууллагын зэрэг хүмүүсийг сургах нь төслийг бусад аймагт өргөжүүлэхэд дараа ашиглах сайн талтай.

## Зохион байгуулалтын бүтэц

6. Аймгийн ажлын хэсэгт бүх салбарын төлөөлөл байх ёстой. Суманд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гүйцэтгэгч хүмүүсийг энэ бүрэлдэхүүнд оруулах нь чухал.
7. Одоогийн бүтцэд багтаан хүүхдийн оролцоог дэмжих механикм бий болгох ёстой. Янз бүрийн түвшинд хүүхдүүдтэй зөвлөлдөх байдлаар үүнийг хийж болох юм. Олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний төслийн үндэсний болон орон нутгийн ажлын хэсэг олон нийтийн үүсгэл санаачлагатай төлүүдийг боловсруулахад тус болох хүүхдэд тхилолж байгаа бэрхшээлийг тодорхойлох зорилгоор хүүхдүүдтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулж болох билээ.
8. Сайн дурынханы үүрэг ролийг дахин тодотгон, тэдний асуудлыг даруй авч үзэхүй бол төслийн үйл ажиллагаанд саад урчуулж болзошгүй байна. Харин тэднийг урамшуулах асуудлыг мөнгөн бус аргаар, тухайлбал гэр бүлийг нь эрүүл мэндийн даатгалд хамруулах, гавьяа зүтгэлийг нь үнэлэх зэргээр шийдвэрлэж болно.

## НЦСҮХАС/ӨЧНС-г хэрэгжүүлэх

9. НЦСҮХАС/ӨЧНС-г засгийн газрын хэмжээнд сайжруулах нь түүний зохион байгуулах чадварыг дээшлүүлэхийг шаардаж байна. Тодорхой, байнгын ухуулга сурталчилгаа үүнд шаардлагатай. Салбарын хөтөлбөр хариуцсан НҮБ-ын Хүүхдийн сангийн үндэсний ажилтнууд үүнд дэмжлэг үзүүлж чадна. Мөн НЦСҮХАС/ӨЧНС-ийн үйл ажиллагаанд НҮБ-ын Хүүхдийн сангийн ажилтнууд түлхүү оролцохыг шаардаж байна.

НЦСҮХАС/ӨЧНС-ийн бодлогыг үндэсний салбарын бодлогод тусгахын чухлыг НҮБ-ын Хүүхдийн сан онцлон анхааруулах ёстой. Зарим нэг ийм бодлого боловсруулалтын шатандаа байна. Засгийн газар Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НЦСҮХАС/ӨЧНС-г ашиглаж байгааг НҮБ-ын Хүүхдийн сан харж байх ёстой.

10. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төслийг буй болгоход НЦСҮХАС/ӨЧНС-г ашиглахдаа энгийн, цаг хугацаа бага шаардахаар хийх ёстой. Орон нутгий ажилтнууд цаг их шаардсан үйл ажиллагааг онцлон хэлж байсан билээ. Айл өрхүүд ч, ажилтнууд ч боловсруулалтын ажилд их цаг зарах нь хэцүү юм.

Хүүхдийн төлөө нэмэлт нөөц бололцоог дайчлах нь

11. Засгийн газрын төсөв бага ч гэсэн НЦСҮХАС/ӨЧНС-г хэрэгжүүлэхэд нэмэлт нөөц бололцоог дайчлах боломжтой билээ. Засгийн газрын төсвийг хээлцэх хугацаанд олон нийтийн үүсгэл санаачлагатай төслүүийг бэлтгэн нэмэлт нөөцийг дайчлан гаргуулах нь хялбар юм. ҮБ-ын Хүүхдийн сангаас ч зохистой үед нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
12. Засгийн газар хүүхдийн төлөө нэмэлт эх үүсвэрийг ниймийн салбар доторх төсвийн бүтцийг зохицуулах замаар бий болгож болно. Хэрвээ ийм ажил өмнө хийгдэж байгаагүй бл НҮБ-ын Хүүхийн сан энэ талаар судалгаа хийхэд нь туслах ёстой. Нийгмийн үйлчилгээг эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтайаар хүргэх боломжийг энэ судалгаанд хамруулан судлах ёстой.
13. Олон нийтийн нөөц бололцоог дайчилж болохыг НЦСҮХАС/ӨЧНС-ийн туршлага харуулсан билээ. Гэхдээ энэ нь ӨЧНС-г өөр газарт өргөжүүлэн хэрэгжүүлэхэд ашиглах бололцоотой юм.
14. Ихээхэн чухал нэмэлт эх үүсвэр бол хандивлагч байгууллагууд юм. Монгол улсыг дэмждэг сайн санаат хандивлагч байгууллагууд зөндөө байгаа бөгөөд тэдний ажиллах нөхцөл ч сайн байна. НҮБ-ын Хүүхдийн сан хүүхдэд чиглэгдсэн хөтөлбөрүүдэд эдгээр хандивлагчийн ашиглах ёстой. Засгийн газар хандивлагч байгууллагуудад санал оруулахдаа хамгийн зохистой зорилго бүхий хариуцагч гол байгууллагыг тодорхойлон тогтоох ёстой. ЗТөв засгийн газар орон нутгийн төрийн байгууллагыг төсөл хэрэгжүүлэх зорилгоор хандивлагч байгууллаг руу хандах эрх олгох ёстой.



НЦСҮХАС/ӨЧНС-г хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн сангийн захиргаа, санхүүгийн дэмжлэгийг сайжруулах

15. Орон нутагт жижиг төсөл хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн санийн одоо баримталж байгаа санхүү, захиргааны журам нь таарамж муутай ажээ. Олон нийтийн үүсгэл санаачлагатай төсөл батлагдмагц жилийн төслийн мөнгийг нь нэг мөсөн олгох бололцоог НҮБ-ын Хүүхдийн сан эрэлхийлэх ёстой. Тэгээд төслийн мөнгийг засгийн газрын журам зааврын дагуу зарцуулж, тайланг байнга гаргаж байхыг шаардах ёстой юм.
16. Олон нийтэд тулгуурласан нийгмийн үйлчилгээний төсөл хариуцдаг одоогийн ажилтнуудын тоо аймаг суманд төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чадахааргүй цөөхөн байна. НЦСҮХАС/ӨЧНС-г хэрэгжүүлэхэд менежментийн ба техник дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай нэмэлт боловсон хүчинтэй болох асуудлыг НҮБ-ын Хүүхдийн сан авч үзэх шаардлагатай.

#### Хяналт

17. Суман дах НЦСҮХАС/ӨЧНС-ийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих явдал хангалтгүй байгаа ба хөтөлбөр хэрэгжиж байгаа газрууд дахь үйлчилгээний хүртээмж, санхүүгийн байдал ямар байгааг мэдэх нь үнэхээр хүнд байна. Хөтөлбөрийн б ичиг баримтуудад үйлчилгээний хүртээмж, санхүүгийн байдлын талаар мэдээллийн системтэй болгох шаардлагатай. Энэ талаар систем боловсруулж мөрдөх хэрэгтэй.

## Хавсралт

### Лавлах баримт бичиг

1. *Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги*, Монгол улсын засгийн газар, 2003 он, Улаанбаатар
2. *Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөр, Хэнтий*, Монгол улсын засгийн газар, 2002 он, Улаанбаатар
3. *Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр*, Монгол улсын засгийн газар, 2002 он, Улаанбаатар
4. *Эрүүл мэндийн салбарын стратегийн мастер төлөвлөгөө: Задлан шинжилсэн баримт бичиг, 2004 оны 3 сар*, Монгол улсын засгийн газар, Эрүүл мэндийн яам 2004 он, Улаанбаатар
5. *Эрүүл мэндийн салбар 2002 он, Эхийн эндэгдлийг бууруулах нь Задлан шинжилсэн баримт бичиг, 2002 он*, Эрүүл мэндийн яам 2004 он, Улаанбаатар
6. Н Редди, Э.Сумъяа, Ц.Эрдэнэчимэг нарын *Ажиглалт, Зөвлөмж, Дүгнэлт* Улаанбаатар, Монгол улс
7. *Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл*, 2003 он Хот хөдөөгийн ялгаа, Монгол улсын засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр Улаанбаатар, Монгол улс
8. *Монгол улсын Хүүхэд, Эмэгтэйчүүдийн байдалд дүн шинжилгээ хийсэн тайлан*, 2000 он, ҮБ-ын Хүүхдийн сан, Улаанбаатар, Монгол улс
9. *Дэлхийн банкны хэсгээс улс оронд үзүүлэх тусламжийн стратегийн асуудлаар Олон улсын хөгжлийн ассоциацийн меморандумыг Гүйцэтгэх захиралд танилцуулсан нь* 2004 оны 4 сарын 5, Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг, Дэлхийн банк, 2004 он